

## Мөрдлөг болгох дүрэм

Эдгээр Бизнес эрхлэх дүрэм (цаашид “Дүрэм” гэх) нь хавсаргасан материалуудын хамт Гишүүнчлэлийн гэрээний салшгүй хэсэг юм. Herbalife нь Дүрэмд үе үе өөрчлөлт оруулах боломжтой бөгөөд ямарваа өөрчлөлтийг гишүүдэд цахим шуудангаар мэдэгдэнэ.

### Гарчиг

|          |   |          |
|----------|---|----------|
| <b>1</b> | <b>Эхлэл</b>  | <b>4</b> |
| 1.1      | Гишүүд нь бие даасан бизнес эрхлэгчид   | 4        |
| 1.2      | Өр болон албадан худалдан авалтыг хориглох тухай  | 4        |
| <b>2</b> | <b>Бүтээгдэхүүний борлуулалт</b>  | <b>4</b> |
| 2.1      | Борлуулалтыг хориглох байршил   | 4        |
| 2.2      | Жижиглэнгийн захиалгын маягт, бүртгэл   | 4        |
| 2.3      | Үйлчлүүлэгчид буцаан олголт хийх тухай  | 4        |
| 2.4      | Өндөр дарамт доорх борлуулалт   | 4        |
| 2.5      | Цааш борлуулалт хийх зорилготой гишүүн бус хүнд бүтээгдэхүүн борлуулах тухай  | 5        |
| 2.6      | Бүтээгдэхүүн, шошго, материалд өөрчлөлт оруулах тухай   | 5        |
| 2.7      | Танилцуулга, хэрэглэх заавар  | 5        |
| 2.8      | Өөрийгөө танилцуулах тухай  | 5        |
| <b>3</b> | <b>Сурталчилгаа</b>   | <b>5</b> |
| 3.1      | Мэдэгдэл  | 5        |
| 3.2      | Үнийн мэдээллийг сурталчлах тухай   | 5        |
| 3.3      | Herbalife-ын оюуны өмч  | 5        |
| 3.4      | Хориотой сурталчилгаа   | 6        |
| <b>4</b> | <b>Борлуулалт, маркетингийн төлөвлөгөөний үндэс</b>   | <b>6</b> |
| 4.1      | Нэг хүнд нэг л гишүүнчлэлийг зөвшөөрөх тухай  | 6        |
| 4.2      | Зохистой худалдан авалт   | 6        |
| 4.3      | Гишүүнчлэлд туслалцаа үзүүлж буй бусад этгээдийн биеэ авч явах байдлыг хариуцах тухай   | 6        |
| 4.4      | Идэвхгүй байх хугацаа   | 6        |
| 4.5      | Жижиглэнгийн 10 үйлчлүүлэгч   | 7        |
| 4.6      | 70%   | 7        |
| <b>5</b> | <b>Спонсорлол, манлайлал</b>  | <b>7</b> |
| 5.1      | TAB Team-ийн гишүүний гэрээ   | 7        |
| 5.2      | Хөндлөнгөөс оролцохгүй байх тухай   | 7        |
| 5.3      | Herbalife-тай холбож ярих тухай   | 7        |
| 5.4      | Бусад боломжуудад татах тухай   | 7        |
| 5.5      | Ашиг олох зориулалтгүй бизнес хэрэгслүүдийг борлуулах тухай   | 7        |
| <b>6</b> | <b>Шууд борлуулалт</b>  | <b>7</b> |
| 6.1      | Борлуулалт, маркетингийн төлөвлөгөөг урвуулан ашиглах тухай   | 8        |
| 6.2      | Үйлчлүүлэгчдэд үзүүлэх үйлчилгээ  | 8        |
| 6.3      | Багийн манлайлал, сургалт   | 8        |
| 6.4      | Дуудлага худалдааны сайт, гуравдагч этгээдийн онлайн худалдааны захуудаар (хамтад нь “Гуравдагч этгээдийн сайтууд” гэх) борлуулалт хийхийг хориглох тухай | 8        |
| 6.5      | Гишүүдийн вэбсайт, аппликейшн   | 9        |
| 6.6      | Хайлтын систем дээрх сурталчилгаа, өөрийн вэбсайтын илэрцийг сайжруулах арга хэмжээ   | 9        |
| 6.7      | Хориотой арилжааны үйл ажиллагаа  | 9        |
| 6.8      | Боломжит үйлчлүүлэгч, тэдний холбоо барих мэдээлэл  | 9        |

|           |  |           |
|-----------|--|-----------|
| <b>7</b>  | <b>Эрүүл амьдралын хэв маягийн клуб, оффис .....</b>   | <b>10</b> |
| 7.1       | Түрээсэлж буй эсвэл худалдаж авсан бизнесийн байршил.....  | 10        |
| 7.2       | Хэд хэдэн клуб.....  | 10        |
| 7.3       | Гишүүд Эрүүл амьдралын хэв маягийн клубийн тухай зөвлөгөө өгснийхөө төлөө төлбөр авах боломжгүй тухай.....                 | 10        |
| 7.4       | Хариуцлагатай клуб зохион байгуулагч.....  | 10        |
| 7.5       | Клубийн байрыг хуваалцах тухай.....  | 10        |
| 7.6       | Бүтээгдэхүүний жижиглэнгийн борлуулалт.....  | 10        |
| 7.7       | Бүтээгдэхүүн бэлдэх тухай .....  | 10        |
| 7.8       | Хүргэлт.....   | 11        |
| 7.9       | Клубийг ашиг олох зорилгоор зарахыг хориглох тухай .....   | 11        |
| 7.10      | Арилжааны клубийн гадна нэр, тэмдэглэгээ.....  | 11        |
| 7.11      | Арилжааны клубийн гадна тохижилт.....  | 11        |
| <b>8</b>  | <b>Олон улсын бизнес .....</b>   | <b>11</b> |
| 8.1       | Хараахан нээлттэй болоогүй улс орон, нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах тухай .....                                      | 11        |
| 8.2       | Бүтээгдэхүүн экспортлохгүй.....  | 12        |
| 8.3       | Хятад дахь үйл ажиллагаа .....   | 12        |
| 8.4       | Хориотой улс/бүс нутаг, хүмүүс .....   | 12        |
| <b>9</b>  | <b>Хэрхэн биеэ авч явах тухай үндсэн дүрэм .....</b>   | <b>12</b> |
| 9.1       | Холбогдох хууль тогтоомж, дүрмийг дагаж мөрдөх .....   | 12        |
| 9.2       | Herbalife-т үнэн зөв мэдээлэл өгөх ба харилцах.....  | 12        |
| 9.3       | Herbalife-ын нэр хүнд ба имижийг хадгалах .....  | 12        |
| 9.4       | Дарамт, ялгаварлан гадуурхалт, зүй бус үйлдлийн хувьд баримтлах дүрэм .....  | 12        |
| 9.5       | Herbalife-ын байр суурийг дагаж мөрдөх .....   | 12        |
| 9.6       | Өрсөлдөөний эсрэг үйлдэл хийхгүй байх.....   | 13        |
| 9.7       | Тоглоомт промоушен.....  | 13        |
| <b>10</b> | <b>Захиргааны хэсэг .....</b>  | <b>14</b> |
| 10.1      | Гишүүнчлэлийн эрх авахад тавигдах шаардлага .....  | 14        |
| 10.1.1    | Гишүүнчлэлийн эрх авах насны доод хязгаар .....  | 14        |
| 10.1.2    | Гэр бүлийн хүн эсвэл Хамтран амьдрагчийг бүртгэлд нэмж оруулах .....   | 14        |
| 10.2      | Гишүүнчлэлийн эрхийг шилжүүлэх .....   | 14        |
| 10.2.1    | Гишүүнчлэлийн эрхийг шилжүүлэх, худалдах, дамжуулах.....   | 14        |
| 10.2.2    | Гишүүнчлэлийн эрхийг зөвхөн Herbalife-ын гишүүн бус хүнд борлуулж, дамжуулах буюу шилжүүлж болно .....                     | 14        |
| 10.2.3    | Шатлал, статус, эрх, хөнгөлөлт.....  | 14        |
| 10.2.4    | Эрх шилжүүлсний дараах хариуцлага .....  | 15        |
| 10.3      | Хамтран амьдрагчаасаа тусдаа амьдрах, салах, харилцаагаа цуцлах .....  | 15        |
| 10.3.1    | Шинэ гишүүнчлэл үүсгэх .....   | 15        |
| 10.3.2    | Анхны гишүүнчлэлд өөрчлөлт оруулах хүсэлт .....  | 16        |
| 10.3.3    | Өөр спонсорын багт орох/өөр гишүүнчлэлд оролцох .....  | 17        |
| 10.3.4    | Гэр бүл салалт, хамтран амьдрагчийн харилцаа дуусгавар болох болон Herbalife-ын Борлуулалт ба маркетингийн төлөвлөгөө..... | 17        |
| 10.4      | Өв залгамжлах* .....   | 19        |
| 10.5      | Үйл ажиллагаагаа зогсоох .....   | 19        |
| 10.6      | Хэрэглэгчдэд борлуулалт хийх .....   | 19        |
| 10.7      | Бизнесийн бүртгэл, татвар.....   | 19        |
| 10.8      | Төлбөр урамшуулал ба дахин тооцоолол.....  | 20        |
| 10.9      | Спонсорын эгнээг хамгаалах, хадгалах .....   | 20        |
| 10.9.1    | Спонсор өөрчлөх .....  | 20        |
| 10.9.2    | Спонсороо өөрчлөх хүсэлт гаргах.....   | 21        |
| 10.10     | Дүрмийн хэрэгжилтийг хангах журам.....   | 22        |
| 10.10.1   | Гомдол гаргах журам .....  | 22        |
| 10.10.2   | Шалгах явц .....   | 22        |
| 10.10.3   | Авах арга хэмжээ.....  | 22        |
| 10.10.4   | Дахин хянан үзэх тухай хүсэлт (Гишүүнчлэлийн эрх цуцалсантай холбоогүй) .....  | 23        |
| 10.10.5   | Гишүүнчлэлийн эрхийг цуцлах.....   | 23        |
| 10.10.6   | Эрх цуцалсан шийдвэрт давж заалдах .....   | 23        |
| 10.11     | Хуулийн нэмэлт заалтууд .....  | 25        |
| 10.11.1   | Хохирол.....   | 25        |
| 10.11.2   | Эрхээсээ татгалзах буюу эсвэл хугацаа алдаж эрхээ эдлэх .....  | 25        |
| 10.11.3   | Тусгаар байдал .....   | 25        |

|         |  |    |
|---------|--|----|
| 10.11.4 | Хэрэглэх хууль, маргаан шийдвэрлэх газар ..... | 25 |
| 10.11.5 | Хохирлыг нөхөн төлөх .....                     | 25 |
| 10.11.6 | Гишүүд хоорондын нэхэмжлэл.....                | 25 |
| 10.12   | Мэдээллийн аюулгүй байдал ба нууцлал .....     | 26 |
| 10.13   | Нэр томъёоны тодорхойлолт.....                 | 27 |

## 1 Эхлэл

### 1.1 Гишүүд нь бие даасан бизнес эрхлэгчид

Гишүүд нь бие даасан гэрээлэгчид бөгөөд өөрсдийн төлөө ажилладаг хувиараа бизнес эрхлэгчид юм. Тэд Herbalife компани болон бусад гишүүдийн ажилтан, франчайз эзэмшигч эсвэл төлөөлөгч биш бөгөөд үүнээс өөрөөр өөрийгөө тайлбарлаж болохгүй. Спонсор нь бусад гишүүд эсвэл өөрийн доод багийн гишүүдийг ердөө багт нь байгаа гэх үндэслэлээр өөрийн ажилтнууд мэтээр харьцаж болохгүй.

Хэрэв спонсор бусад гишүүдтэй хөдөлмөрийн харилцаатай бол тухайн спонсор нь бүх хөдөлмөрийн хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүрэгтэй.

Ажилтнууд гишүүний үйл ажиллагаанд оролцож болохгүй.

Гишүүд нь Үйлчлүүлэгчид үзүүлэх үйлчилгээний дүрэмд тусгасан үйлчилгээний бүх үүргийг биечлэн гүйцэтгэх ёстой.

### 1.2 Өр болон албадан худалдан авалтыг хориглох тухай

Herbalife-ын Гишүүнчлэлийн багцаас өөр худалдан авалт хийхийг шаардаж болохгүй ба өр тавих үйлдлийг дэмжихгүй.

HMP-ийг нэмэгдэл үнэ болон ашиг тооцохгүйгээр, зөвхөн өртгийн үнээр эсхүл түүнээс доогуур үнээр олгох ёстой.

## 2 Бүтээгдэхүүний борлуулалт

### 2.1 Борлуулалтыг хориглох байршил

Гишүүд Herbalife®-ын бүтээгдэхүүнүүдийг (нээлтэй эсвэл хаалттай) зах, эмийн сан, мухлаг, (түр эсвэл байнгын) лангуу, бартер, хуучин эдлэлийн зах, явуулын хоолны газар, ачааны контейнер, ресторан, хоолны үйлчилгээний газрууд эсвэл үүнтэй төстэй бусад байршлуудад борлуулахыг хориглоно.

Үйлчилгээг хаалттай өрөөнд үзүүлж байгаа тохиолдолд хүлээн зөвшөөрнө.

### 2.2 Жижиглэнгийн захиалгын маягт, бүртгэл

Гишүүд нь худалдан авалт хийсэн тохиолдол бүрийн дараа үйлчлүүлэгчид бүрэн мэдээллийг агуулсан Жижиглэнгийн захиалгын маягт өгөх ба бүх Жижиглэнгийн захиалгын маягтын хуулбар болон бүтээгдэхүүн түгээж, борлуулсан тухай бусад бүх бүртгэлийг хоёр (2) жилийн хугацаанд хадгалах үүрэгтэй.

Herbalife нь борлуулалтын гүйлгээ болон нөхцөлийг хянах зорилгоор үйлчлүүлэгчид бүтээгдэхүүн борлуулсан тухай бүртгэлийн хуулбарыг гаргаж өгөхийг хүсэх эрхтэй бөгөөд гишүүн нь хүсэлтийн дагуу уг бүртгэлийг гаргаж өгөх үүрэгтэй.

### 2.3 Үйлчлүүлэгчид буцаан олголт хийх тухай

Гишүүд нь үйлчлүүлэгчдэд мөнгийг буцааж олгох 30 хоногийн баталгааг санал болгох үүрэгтэй.

Тээвэрлэлт болон захиалга боловсруулалтын бүх зардлыг багтаасан бүрэн буцаан олголт авах эсвэл Herbalife®-ын өөр бүтээгдэхүүнээр солих сонголтыг үйлчлүүлэгчид санал болгох ёстой.

Гишүүд нь давуу эрхт үйлчлүүлэгчдэд буцаан олголтыг авахаар компанитай холбогдох хэрэгтэйг зөвлөнө.

### 2.4 Өндөр дарамт доорх борлуулалт

Гишүүд нь үйлчлүүлэгчид, давуу эрхт үйлчлүүлэгчид болон гишүүддээ борлуулалт хийхээр дарамт, шахалт үзүүлж болохгүй.

## 2.5 Цааш борлуулалт хийх зорилготой гишүүн бус хүнд бүтээгдэхүүн борлуулах тухай

Гишүүд нь цааш борлуулалт хийх зорилго агуулсан гишүүн бус хүнд Herbalife®-ын бүтээгдэхүүнүүдийг борлуулж эсвэл ямарваа байдлаар олгож болохгүй.

## 2.6 Бүтээгдэхүүн, шошго, материалд өөрчлөлт оруулах тухай

Гишүүд нь Herbalife®-ын бүтээгдэхүүний шошго, бичиг баримт, материал, эсвэл савлагааг өөрчилж эсвэл хуурамчаар үйлдэж болохгүй. Гишүүд нь Herbalife®-ын бүтээгдэхүүний савлагааг сольж болохгүй ба салгаж борлуулах зориулалтгүй шошго, тайлбартай бүтээгдэхүүнийг тус тусад нь борлуулж болохгүй.

## 2.7 Танилцуулга, хэрэглэх заавар

Herbalife®-ын бүтээгдэхүүнүүдийг борлуулах эсвэл амталгаа байдлаар өгөх тохиолдолд гишүүд нь бүтээгдэхүүний шошго дээрх хэрэглэх заавар, мөн байгаа тохиолдолд анхааруулгыг заавал тайлбарлаж өгөх үүрэгтэй.

Гишүүд нь эрүүл мэндийн асуудалтай эсвэл эмчилгээ хийлгэж байгаа үйлчлүүлэгчдэдээ хооллолтоо өөрчлөхөөс өмнө эмчийн зөвлөгөө авахыг сануулах ёстой.

Гишүүд нь Herbalife®-ын бүтээгдэхүүнийг борлуулахаасаа өмнө бүтээгдэхүүний тухайн үеийн шошго дээрх мэдээллийг үйлчлүүлэгчдэд хүргэсэн байх ёстой.

## 2.8 Өөрийгөө танилцуулах тухай

Herbalife®-ын бүтээгдэхүүнүүдийг борлуулах эсвэл сурталчлах, бизнес боломжийг танилцуулах үедээ гишүүд нь өөрийгөө Herbalife-ын гишүүн гэж танилцуулах ёстой.

# 3 Сурталчилгаа

## 3.1 Мэдэгдэл

Мэдэгдэл буюу баталгаа гэдэг нь Herbalife®-ын бүтээгдэхүүнүүд, Herbalife-ын бизнес боломж, эсхүл тэдгээрийн ашиг тусын талаарх ямарваа тайлбар, түүх, зураг, видеог хэлнэ. Гишүүд нь дараах шаардлагыг хангасан мэдэгдлийг хийх боломжтой. Үүнд:

- Үнэн зөв, төөрөгдөлд оруулаагүй, бичгээр үйлдсэн баримтаар баталгаажих ёстой.
- Холбогдох бүх Дүрэм болон хуульд нийцэх ёстой.
- Бүтээгдэхүүний шошго дээрх мэдээлэлтэй нийцсэн байх ёстой.
- Эмчилгээ, өвчин эсвэл анагаахын тал дээр ямарваа мэдэгдэл хийж болохгүй.
- Орлого баталгаатай эсвэл цалинтай ажлын боломж гэх утгыг агуулж болохгүй.
- Хэт өндөр орлого эсвэл тансаг амьдралын хэв маягийн утга, дүрслэлийг агуулж болохгүй.
- Зохио газар нь ойлгоход хялбар нэмэлт тайлбар, санамжийг ашиглах ёстой.

Herbalife нь эдгээр Дүрэм, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн, Herbalife брэндийн нэр хүндийг гутаасан аливаа мэдэгдлийг устгахыг шаардах эрхтэй.

## 3.2 Үнийн мэдээллийг сурталчлах тухай

Herbalife өөрийн платформууд дээр зөвшөөрч, байршуулсан мэдээллээс бусдаар гишүүд нь үнийн тухай мэдээллийг олон нийтэд дэлгэж болохгүй.

## 3.3 Herbalife-ын оюуны өмч

Herbalife нь зохиогчийн эрхтэй материалуудыг гишүүд ашиглах боломжтой байдлаар гаргадаг ба Herbalife-ын барааны тэмдгийг дараах нөхцөлөөр ашиглахыг зөвшөөрдөг. Үүнд:

- Материалуудыг зөвхөн Herbalife®-ын бүтээгдэхүүнүүдийн борлуулалт, хэрэглээг нэмэгдүүлэх, эсвэл бизнес боломжийг сурталчлах зорилгоор ашиглах ёстой.
- Материалуудыг компаниас албан ёсоор зөвшөөрсөн платформуудаас татаж авна.
- Текст, зураг, барааны тэмдгийг ямар нэгэн байдлаар өөрчлөх, тайрах, засварлах боломжгүй.

- Материалууд нь Herbalife компанийн өмч гэдгийг гишүүд мэдэгдэнэ.
- Гишүүд ямарваа сурталчилгаандаа Марк Хьюзын нэр эсвэл дүрсийг хэзээ ч ашиглахгүй.
- Гишүүд нь тэдгээрийг ямарваа вэбсайтын домэйн нэр, бүртгэл, эсвэл гадна тэмдэглэгээ дээр ашиглахгүй.
- Гишүүд нь Herbalife-ын хүсэлтээр зохиогчийн эрх болон барааны тэмдэгтэй аливаа материалыг ашиглахаа зогсооно.
- Гишүүд нь нэр хүндээ өндөрт хадгална.

Herbalife нь ямарваа худалдааны нууцыг гишүүнтэй хуваалцсан тохиолдолд тухайн гишүүн арилжааны нууцыг нууц хэвээр хадгалж, гэрээ дуусгавар болсон эсвэл гэрээг цуцалсны дараа ч задруулахгүй.

Нөгөөтээгүүр гишүүд нь бусад этгээд эсвэл аж ахуйн нэгжид хамаарах аливаа аудио, дүрс бичлэг, барааны тэмдэг, компанийн нэр, бүтээгдэхүүний нэр, график дүрслэлийг эзэмшигчээс нь зөвшөөрөл авалгүйгээр Herbalife-ын бизнестээ ашиглаж болохгүй.

### 3.4 Хориотой сурталчилгаа

Гишүүд телевиз, радио болон бусад ижил төстэй мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэг, сурталчилгаа цацаж болохгүй.

Үүнээс гадна, гишүүд нь сонин, сэтгүүл, сурталчилгааны хуудас, утасны дэвтэр, баннер, сурталчилгааны самбар болон түүнтэй адилтгах хэвлэмэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа цацаж болохгүй.

## 4 Борлуулалт, маркетингийн төлөвлөгөөний үндэс

### 4.1 Нэг хүнд нэг л гишүүнчлэлийг зөвшөөрөх тухай

Манай Өв залгамжлалын тухай бодлогын дагуу зөвшөөрснөөс бусад тохиолдолд хувь хүн Herbalife-ын зөвхөн нэг гишүүнчлэлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах боломжтой. Гишүүн хүн давхар давуу эрхт үйлчлүүлэгч байж болохгүй. Гэрлэсэн хос болон хамтран амьдрагч болсон хүмүүс гэрлэлтээ бүртгүүлэх эсвэл хамтран амьдарч эхлэх үедээ аль аль нь Супервайзор статуст байгаагүй бол нэг гишүүнчлэл дор үйл ажиллагаагаа хамт явуулах ёстой.

### 4.2 Зохистой худалдан авалт

Супервайзор бус гишүүд нь Herbalife®-ын бүтээгдэхүүнүүдийг зөвхөн Herbalife компани, өөрийн спонсор, эсвэл дээд багийн анхны бүрэн баталгаажсан Супервайзороос худалдаж авах боломжтой.

Гишүүд бусад гишүүний эсвэл давуу эрхт үйлчлүүлэгчийн нэр дээр (Herbalife тухайн хүнээс бичгээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд) захиалга өгөх эсвэл төлбөр төлөх боломжгүй.

Супервайзорууд нь бүтээгдэхүүнүүдийг зөвхөн компаниас шууд худалдан авах боломжтой.

Борлуулалт, маркетингийн төлөвлөгөөнд заасан болзол, орлого болон давуу эрхэд зөвхөн Herbalife-аас шууд худалдан авсан бүтээгдэхүүний захиалгыг тооцно.

### 4.3 Гишүүнчлэлд тусалцаа үзүүлж буй бусад этгээдийн биеэ авч явах байдлыг хариуцах тухай

Гишүүд нь гэр бүлийн хүн, хамтран амьдрагч эсвэл гишүүнд үйлчилгээ үзүүлж буй хөндлөнгийн этгээд зэрэг бизнест нь тусалж буй хэн бүхний үйлдлийг хариуцна.

### 4.4 Идэвхгүй байх хугацаа

Өөр спонсорын дор шинэ Гишүүнчлэлийн гэрээнд гарын үсэг зурах гэж буй аливаа гишүүн (Супервайзор болон түүнээс доош статустай бол) нэг жил эсвэл (World Team болон түүнээс дээш статустай бол) хоёр жил хүлээх ёстой бөгөөд энэ хугацаанд тэд гишүүний ямар ч үйл ажиллагаа явуулж болохгүй.

Энэхүү шаардлага өмнөх оролцогч (тодруулбал, хуучин гишүүн, эхнэр/нөхөр, амьдралын хань эсвэл гишүүнчлэлд тусалж байсан этгээд)-д мөн адил хамаарна.

Хуучин давуу эрхт үйлчлүүлэгчид хүлээлтийн 180 хоногийг дуусгах хэрэгтэй.

Тусламж авах эсвэл өөр аргаар идэвхгүй байх хугацааг тойрч гарах оролдлого хийхийг хориглоно.

#### **4.5 Жижиглэнгийн 10 үйлчлүүлэгч**

Гишүүн нь орлого авах эрхтэй байхын тулд тухайн сард хамгийн багадаа тус бүр арван (10) үйлчлүүлэгчид борлуулалт хийсэн гэдгээ цаг тухайд нь баталгаажуулах ёстой.

Үйлчлүүлэгч гэдэгт дараах хүмүүс тооцогдоно. Үүнд:

- Жижиглэнгийн үйлчлүүлэгч;
- Нэгдүгээр үеийн давуу эрхт үйлчлүүлэгч;
- Хувиараа худалдан авсан 200 хүртэлх оноотой нэгдүгээр үеийн (доороо гишүүнгүй) гишүүн байвал түүнийг нэг (1) жижиглэнгийн үйлчлүүлэгчид борлуулалт хийсэн гэж тооцно.

#### **4.6 70%**

Гишүүн нь орлого авах эрхтэй байхын тулд сар бүр худалдаж авсан нийт онооныхоо 70-аас багагүй хувийг борлуулсан гэдгээ цаг тухайд нь баталгаажуулах ёстой.

### **5 Спонсорлол, манлайлал**

#### **5.1 ТАВ Team-ийн гишүүний гэрээ**

Гишүүн нь ТАВ Team статус хүрмэгцээ Борлуулалтын урамшуулал авах эрхтэй болохоосоо өмнө ТАВ Team-ийн гишүүний гэрээнд гарын үсэг зурах ёстой.

#### **5.2 Хөндлөнгөөс оролцохгүй байх тухай**

Гишүүд нь бусад гишүүдийн бизнест хөндлөнгөөс оролцох эрхгүй.

#### **5.3 Herbalife-тай холбож ярих тухай**

Гишүүд Herbalife-ыг шашин, улс төр, нийгмийн итгэл үнэмшил, аливаа байгууллага эсвэл бусад бизнестэй холбоотой гэж ярьж, танилцуулж болохгүй.

#### **5.4 Бусад боломжуудад татах тухай**

Гишүүд бусад бизнесийн боломжуудыг гишүүд эсвэл давуу эрхт үйлчлүүлэгчдэд сурталчилж болохгүй.

Мөн гишүүд нь бусад олон үет маркетингийн буюу шууд борлуулалтын компаниудын бүтээгдэхүүнүүдийг гишүүд эсвэл давуу эрхт үйлчлүүлэгчдэд борлуулж болохгүй.

#### **5.5 Ашиг олох зориулалтгүй бизнес хэрэгслүүдийг борлуулах тухай**

Гишүүд нь бизнес хэрэгслүүдийг бусад гишүүдэд борлуулж орлого олж болохгүй бөгөөд Herbalife нь өөрсдийн Дүрэм, хууль тогтоомжийг зөрчсөн эсвэл Herbalife-ын нэр хүнд, дүр төрхийг хохироосон бизнес хэрэгслийг худалдах, ашиглахыг хориглох эрхтэй.

### **6 Шууд борлуулалт**

**Herbalife-ын бизнесийн боломж, Борлуулалт, маркетингийн төлөвлөгөө болон түгээлтийн сувгийн бүрэн бүтэн байдлыг хадгалж хамгаалан, учирч болзошгүй хохиролоос урьдчилан сэргийлэх нь Herbalife болон манай бизнес загварын хувьд нэн тэргүүний ач холбогдолтой.**

**Энэхүү Шууд борлуулалтын хэсэгт заасан Дүрмийг зөрчвөл Гишүүнчлэлийн гэрээг ноцтой зөрчсөн үйлдэл болох бөгөөд Herbalife нь Гишүүнчлэлийн гэрээг цуцлах хүртэл боломжтой бүх арга хэмжээг авах эрхтэй.**

## 6.1 Борлуулалт, маркетингийн төлөвлөгөөг урвуулан ашиглах тухай

Гишүүд Борлуулалт, маркетингийн төлөвлөгөөг урвуулан ашигласан ямарваа үйл ажиллагаа, хуйвалдаан, зохион байгуулалтад шууд болон шууд бусаар оролцож болохгүй. Гишүүд Борлуулалт, маркетингийн төлөвлөгөөний дагуу өөрөө эсвэл өөр нэгэн гишүүн багийнхаа олон үеэс урамшуулал авах эсвэл сайшаал хүртэхэд хүргэх үндсэн зорилготой бүтээгдэхүүн худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж болохгүй (энэ нь үйлчлүүлэгчид борлуулах зорилготойгоор эсвэл хувийн хэрэглээнд зориулж худалдан авсан бүтээгдэхүүний байж болохуйц хэмжээнээс ялгаатай).

Борлуулалт, маркетингийн төлөвлөгөөг урвуулан ашигласныг илтгэж болох жишээнүүдийн бүрэн бус жагсаалтыг [эндээс](#) авах боломжтой.

### Зөрчил, хориг арга хэмжээ

Борлуулалт, маркетингийн төлөвлөгөөг урвуулан ашигласан тохиолдол нь Гишүүнчлэлийн гэрээний ноцтой зөрчил юм. Тиймээс Herbalife үүнийг залруулах бүх боломжит арга хэмжээг авах эрхтэй бөгөөд тэр дунд урьдчилан бичгээр мэдэгдэлгүйгээр Гишүүнчлэлийг цуцлах эрхтэй.

Гишүүн нь Борлуулалт, маркетингийн төлөвлөгөөг урвуулан ашигласны улмаас Herbalife компанид учирсан аливаа болон бүх хохирлыг мөн хариуцна.

Бусад хориг арга хэмжээнд үүнд (шууд эсвэл шууд бусаар) холбогдсон хэн бүхний орлогыг дахин тооцоолох, хасах, Гишүүнчлэлийн болзол цуцлагдах зэрэг багтана. Дээд багийн гишүүдэд санхүүгийн хохирол учруулахаас сэргийлэхийн тулд шалгалт хийж байх үе шатанд таны Гишүүнчлэлд тодорхой арга хэмжээ авах шаардлага гарч болно. Тухайлбал, худалдан авах эрхийг түр хаах.

## 6.2 Үйлчлүүлэгчдэд үзүүлэх үйлчилгээ

Гишүүд нь үйлчлүүлэгч Herbalife-ын бүтээгдэхүүний анхны худалдан авалтаа хийхээс өмнө түүнтэй биечлэн эсвэл онлайнгаар харилцаж, тухайн хүнд хандсан үйлчилгээний арга барилыг баримтлах ёстой. Гишүүд хувийн харилцаагаар дамжуулан, бусдаас ялгарах үйлчилгээ үзүүлэх нь чухал.

Үйлчлүүлэгчийн анхны худалдан авалтаас өмнө гишүүдийн үзүүлэх шаардлагатай суурь үйлчилгээнүүдийн жагсаалтыг [эндээс](#) авах боломжтой.

Бүтээгдэхүүнүүдийг хэрэглэж, хамгийн сайн үр дүнд хүрэхэд нь туслах зорилгоор гишүүд нь цаашид ч үйлчлүүлэгчид дэмжлэг үзүүлсээр байх ёстой.

Жишээнүүдийн бүрэн бус жагсаалтыг [эндээс](#) авах боломжтой.

## 6.3 Багийн манлайлал, сургалт

Спонсорууд доод багийн гишүүддээ сургалт орох үүрэгтэй. Гэхдээ үүнээс ашиг олж болохгүй.

Жишээнүүдийн бүрэн бус жагсаалтыг [эндээс](#) авах боломжтой.

## 6.4 Дуудлага худалдааны сайт, гуравдагч этгээдийн онлайн худалдааны захуудаар (хамтад нь “Гуравдагч этгээдийн сайтууд” гэх) борлуулалт хийхийг хориглох тухай

Гуравдагч этгээдийн сайтуудаар борлуулалт хийхэд гишүүд үйлчлүүлэгчидтэйгээ тогтоох ёстой хувь хүн хоорондын харилцаа төдийгүй Herbalife брэнд, брэндийн дүр төрх, бүтээгдэхүүнүүдийн зах зээлд эзлэх байр суурь сулардаг.

Үүний зарим шалтгааныг дурдвал:

- Гуравдагч этгээдийн сайтууд нь Гуравдагч этгээдийн сайтыг ажиллуулж буй байгууллагын нэр болон логог харуулдаг;
- Ихэнх тохиолдолд бүтээгдэхүүний чанар эсвэл нөлөөллийн талаар худал эсвэл бүр хууль бус байж болох буруу мэдээллийг хүргэдэг;
- Herbalife-ын бүтээгдэхүүнүүдийг Herbalife компанийн зүгээс өөрийн бүтээгдэхүүнд бий болгосон зах зээлд эзлэх байр суурь, дүр төрхтэй нийцэхгүй агуулгын дунд байрлуулдаг.

Өөрсдийн бие даасан онлайн дэлгүүр эсвэл Herbalife-ын бүтээсэн платформоор дамжуулан Herbalife®-ын бүтээгдэхүүнүүдийг онлайнгаар борлуулахыг гишүүдэд **зөвшөөрдөг**.

Гишүүд нь Herbalife-ын бүтээгдэхүүнүүдийг ямарваа арилжааны дуудлага худалдааны вэбсайт, онлайн дуудлага худалдааны талбар, гуравдагч этгээдийн вэбсайт эсвэл гуравдагч этгээдийн вэбсайтын нэр, лого бүхий эсвэл гуравдагч этгээдийн вэбсайт гэдгийг өөр ямарваа хэлбэрээр таниулсан бусад вэбсайтад нээлттэй тендерт оруулахыг хүсэх эсвэл ийм хүсэлтийг хүлээн авч оролцох, эсвэл тогтсон үнээр борлуулахаар нийтлэх эсвэл бусад арга замаар (ямарваа арга эсвэл хэрэгслээр дамжуулан шууд болон шууд бусаар) худалдах санал гаргах, худалдах эсвэл худалдах санал болон худалдах хүсэлтэд туслахыг **хориглоно**.

Herbalife®-ын бүтээгдэхүүнүүдийг борлуулахад олон нийтийн цахим сүлжээний сайтуудыг ашиглаж болохгүй.

### **6.5 Гишүүдийн вэбсайт, аппликейшн**

Herbalife®-ын бүтээгдэхүүнүүдийг сурталчлах, борлуулах зорилгоор Herbalife компанийн худалдааны тэмдгийг ашигладаг бие даасан вэбсайт болон аппликейшн ажиллуулдаг гишүүд нь дараахыг анхаарах ёстой. Үүнд:

- Вэбсайтад зочлох бүрд нэг удаа гарч ирдэг Herbalife-аас олгосон поп-ап цонхыг ямар нэгэн өөрчлөлт оруулалгүйгээр тодорхой харуулах ёстой;
- Гишүүний нэр болон хаяг, утасны дугаар зэрэг холбоо барих мэдээллийг “Herbalife-ын Гишүүн” логотой хамтаар тодорхой харуулах ёстой бөгөөд лого нь сайтаар зочилж буй хүмүүсийн анхаарлыг татахуйц, (цонхны дээд талд) нүдэнд харагдах байрлалд байх ёстой;
- Вэбсайт эсвэл аппликейшн нь Herbalife-ын албан ёсны вэбсайт болон Herbalife-ын албан ёсны аппликейшнуудтай ижил эсвэл төстэй харагдах ёсгүй гэдгийг анхаарч, андуурч болохуйц нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх хэрэгтэй.

Гишүүд бие даасан вэбсайтаа өөрсдөө ажиллуулах ёстой бөгөөд нэг вэбсайт дээр нэгээс олон гишүүн үйл ажиллагаа явуулах, захиалга боловсруулах, эсвэл өөр ямарваа хэлбэрээр оролцох ёсгүй.

### **6.6 Хайлтын систем дээрх сурталчилгаа, өөрийн вэбсайтын илэрцийг сайжруулах арга хэмжээ**

Гишүүд нь ямарваа хайлтын системийн илэрц дээр гишүүний бие даасан вэбсайт болон Herbalife компанийн албан ёсны вэбсайт хооронд андуурагдаж, төөрөгдөл үүсгэж болохгүй.

[Ашиглах хориотой үг/хэллэгийн жагсаалтад](#) онцолсон үг, хэллэг нь гишүүний вэбсайт илэрцээр гарч ирсэн ямарваа хайлтын үр дүнд гарч ирэх ёсгүй.

Төлбөртэй хайлтын системийн зар сурталчилгаа ашиглаж буй гишүүд зар сурталчилгааны хаа нэгтээ **“Herbalife-ын Гишүүн”** гэх үгийг ил харагдахуйц байдлаар байрлуулах ёстой.

### **6.7 Хориотой арилжааны үйл ажиллагаа**

Herbalife®-ын бүтээгдэхүүнүүд болон/эсвэл Herbalife-ын боломжийг санал болгох, сурталчлах, ярихдаа гишүүд нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу төөрөгдүүлсэн, худал мэдээлэл хүргэх, түрэмгий зан байдал гаргах зэрэг аливаа шударга бус арилжааны туршлага ашиглаж болохгүй.

### **6.8 Боломжит үйлчлүүлэгч, тэдний холбоо барих мэдээлэл**

Гишүүд нь боломжит үйлчлүүлэгчид эсвэл тэдний холбоо барих мэдээллийг худалдаж авах эсвэл худалдах хориотой. Гэхдээ тэд өөрсдийн хэрэгцээнд зориулж эсвэл бусдад үнэ төлбөргүй өгөх зорилгоор боломжит үйлчлүүлэгчдээс хүсэлт авах эсвэл бусдаас холбоо барих мэдээллийг авах боломжтой.

Гишүүд дараахыг баталгаажуулахаас нааш боломжит үйлчлүүлэгчийн мэдээллийг доод багийн гишүүнд автоматаар, системээр эсвэл өөр ямарваа аргаар дамжуулах ёсгүй. Үүнд:

- Боломжит үйлчлүүлэгч нь өөр (доод багийн) гишүүн харилцааг зохицуулах болсныг урьдчилж эсвэл уулзах үедээ мэдэж, хүлээн зөвшөөрсөн байна;

- Боломжит үйлчлүүлэгчийг хүлээн авч буй доод багийн гишүүн нь борлуулалт, борлуулалтын дараах үйлчилгээг зохицуулах бүрэн хариуцлагыг хүлээн авч, үйлчлүүлэгчтэй харилцааг хадгалах ёстойг ухамсарласан байна.

## 7 Эрүүл амьдралын хэв маягийн клуб, оффис

### 7.1 Түрээсэлж буй эсвэл худалдаж авсан бизнесийн байршил

Гишүүд дараах шаардлагыг хангах хүртлээ Herbalife-ын бизнесийн үйл ажиллагаа явуулах байр түрээслэх, дэд түрээслэх эсвэл худалдаж авах ёсгүй. Үүнд:

- Хамгийн багадаа 90 хоногийн хугацаанд гишүүн байсан.
- Бүрэн баталгаажсан Супервайзор статуст хүрсэн.
- Herbalife-аас шаардаж буй үйл явцыг биелүүлсэн.
- [MyHerbalife.com](http://MyHerbalife.com) сайтаар орж, Herbalife-д онлайнаар байршлаа бүртгүүлсэн.

### 7.2 Хэд хэдэн клуб

Гишүүд гурваас илүүгүй байршилд үйл ажиллагаа явуулж, эсвэл клуб ажиллуулах зорилгоор гурваас дээшгүй түрээсийн гэрээ байгуулж болно.

### 7.3 Гишүүд Эрүүл амьдралын хэв маягийн клубийн тухай зөвлөгөө өгснийхөө төлөө төлбөр авах боломжгүй тухай

Багийн манлайлал, сургалтын тухай дүрэмд тусгайлан заагаагүй бол гишүүд нь бусад гишүүдэд клуб нээхэд эсвэл зохион байгуулахад тусалсан эсвэл зөвлөгөө өгснийхөө төлөө төлбөр авч болохгүй.

### 7.4 Хариуцлагатай клуб зохион байгуулагч

Клубийн бүх үйл ажиллагааг хариуцаж, хянах үндсэн зохион байгуулагчаар нэг гишүүн томилогдсон байна.

Клубийн үндсэн зохион байгуулагч нь өөрийн эзгүйд клубийн үйл ажиллагааг хариуцах өөр нэгэн гишүүнийг томилох ёстой.

### 7.5 Клубийн байрыг хуваалцах тухай

Клубийн зохион байгуулагч нь бусад гишүүдээс клубийг ашигласан зардлыг л хураамжилж болох бөгөөд тэднээс ашиг олж болохгүй. Клубийн орон зайг дэд түрээсэлж буй бүх гишүүд Түрээсэлж буй эсвэл худалдаж авсан бизнесийн байршлын тухай дүрэмд заасан бүх шаардлагыг хангасан байх ёстой.

### 7.6 Бүтээгдэхүүний жижиглэнгийн борлуулалт

Савлагаатай хэдий ч тус тусад нь шошголоогүй бүтээгдэхүүнийг жижиглэнгээр борлуулахын тулд гишүүд нь дотоодын хууль тогтоомжийн дагуу борлуулсан бүтээгдэхүүний шошго дээрх бүх мэдээллийг гаргаж өгөх шаардлагатай.

Шахмал бүтээгдэхүүнийг ширхгээр нь борлуулах эсвэл санал болгохыг хориглох ба дахин савласан хуурай бүтээгдэхүүн борлуулахыг мөн хориглоно.

### 7.7 Бүтээгдэхүүн бэлдэх тухай

Гишүүд Эрүүл амьдралын хэв маягийн клубт ирэх үйлчлүүлэгчдийг дайлах бүтээгдэхүүнүүдийг хүлээн зөвшөөрөгдөх аргаар бэлтгэж, бүтээгдэхүүний шошго дээрх мэдээлэл, харшил үүсгэгчдийн тухай мэдээллийг үйлчлүүлэгчдэд нээлттэй хүргэх ёстой. Бүтээгдэхүүнийг шошго дээрх зааврын дагуу бэлтгээгүй тохиолдолд бүтээгдэхүүний тухай ямарваа мэдэгдэл хийж болохгүй.

Клубт зөвхөн Herbalife®-ын бүтээгдэхүүнүүд болон түүн дээр нэмэх боломжтой жимс, ногоо, амтлагчдаар үйлчлэх ба тэднийг борлуулах, сурталчлах боломжтой.

## 7.8 Хүргэлт

Гишүүд нь:

- TokTok, Ubcab, Uber Eats, Grubhub зэрэг бусад ижил төстэй хөндлөнгийн хүргэлтийн үйлчилгээ ашиглаж болохгүй; эсвэл
- Үйлчлүүлэгчид машинтайгаа ирээд машинаас гаралгүй эсвэл алхаж ирээд цонхоор үйлчлүүлдэг байж болохгүй.

## 7.9 Клубийг ашиг олох зорилгоор зарахыг хориглох тухай

**Түрээс шилжүүлэх:** Клубийг ашиг олох зорилгоор зарахыг хориглоно. Гэхдээ түрээсийг шилжүүлэх, хөрөнгө хогшил авахад, мөн тохижуулахад зарцуулсан дүнг суутгаж авахыг зөвшөөрнө. Шаардсан тохиолдолд гишүүд зардлыг батлах бүртгэлийг гаргаж өгөх ёстой.

Түрээсийн гэрээ байгуулахаас өмнө гишүүн юун түрүүнд Түрээсэлж буй эсвэл худалдаж авсан бизнесийн байршлын тухай дүрэмд заасан бүх шаардлагыг хангасан байх ёстой.

## 7.10 Арилжааны клубийн гадна нэр, тэмдэглэгээ

Бүртгэлийн үйл явцын нэг хэсэг болгон гишүүд клубийн үйл ажиллагааг явуулах байрыг түрээслэх, дэд түрээслэх, худалдан авахын өмнө клубийн гадна хадах нэр, тэмдэглэгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Herbalife-д хянуулахаар өгсөн байх шаардлагатай.

**Хэрэв гишүүн клубийн гадна нэр, тэмдэглэгээ тавьж байгаа бол дараахыг зөвшөөрөхгүй. Үүнд:**

- Адилхан эсвэл төстэй нэр, тэмдэглэгээ ашиглах;
- Herbalife-ын бүтээгдэхүүнийг худалдаж авах боломжтой гэх санааг илэрхийлэх;
- Эрүүл амьдралын хэв маягийн клубийн франчайз эсвэл сүлжээ клубийн нэг гэх ойлголт төрүүлэхүйц байдлаар тодорхой бүлгийг (газарзүйн байршил, гишүүний баг, клубүүд г.м.) илэрхийлсэн нэр эсвэл тэмдэглэгээ ашиглах; эсвэл
- Herbalife-ын оюуны өмч, бүтээгдэхүүнийн нэр эсвэл брэндийг ашиглах.

Энэ нь гаднаас харагдах, энэ газар франчайз юм гэх санааг илэрхийлэх бүхий л тохижилтод хамаарна.

## 7.11 Арилжааны клубийн гадна тохижилт

Хаалт тавихыг заавал шаардахгүй. Гэхдээ клубийн гадна тохижилт болон хаалт дээр дараахыг хориглоно. Үүнд:

- Herbalife-ын брэндиг байршуулах (нэр, лого г.м.);
- Herbalife-ын бүтээгдэхүүнийг худалдан авах боломжтой гэх ойлголт төрүүлэх;
- “Өмнөх ба дараах” зураг эсвэл харьцуулсан зураг байршуулах; мөн
- Ямар ч хоёр клуб яг ижил эсвэл үндсэн харагдах байдал төстэй хаалт эсвэл гадна тохижилттой байж болохгүй.

Клуб дотор Herbalife®-ын бүтээгдэхүүнүүд, бүтээгдэхүүнүүдтэй холбоотой материал болон сурталчилгааны эд зүйлсийг байлгаж болно. Гэхдээ эдгээр нь клубийн гаднаас харагдаж болохгүй.

# 8 Олон улсын бизнес

## 8.1 Хараахан нээлттэй болоогүй улс орон, нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах тухай

Гишүүд компани албан ёсоор үйл ажиллагаа явуулж эхлээгүй аль ч улсад Herbalife-ын аливаа бизнесийн үйл ажиллагааг эрхэлж болохгүй.

## 8.2 Бүтээгдэхүүн экспортлохгүй

Гишүүд нэг улсаас нөгөө улсруу бүтээгдэхүүн тээвэрлэх, худалдах, экспортлох, түгээх эрхгүй.

Гишүүд холбогдох хууль тогтоомж болон Herbalife-ын бодлогуудын дагуу аялах үедээ сард 1500 хүртэлх онооны бүтээгдэхүүнийг хувийн хэрэгцээнд зориулан авч явах боломжтой.

## 8.3 Хятад дахь үйл ажиллагаа

Хятадад зөвхөн Хятадын иргэд бизнес эрхлэх боломжтой. Гишүүд Herbalife®-ын бүтээгдэхүүнийг хувийн хэрэгцээнд зориулан Хятад руу тээвэрлэх, авч орохыг хориглоно.

## 8.4 Хориотой улс/бүс нутаг, хүмүүс

Гишүүд хориотой улс/бүс нутагт оршин суух эсвэл Herbalife-ын бизнесийн үйл ажиллагаа явуулж болохгүй.

Гишүүн дараах зүйл гэж үзэх үндэслэлтэй хувь хүн, аж ахуйн нэгжтэй Herbalife-ын аливаа бизнесийн үйл ажиллагааг шууд болон шууд бусаар явуулах эрхгүй:

- i. Хориотой улс/бүс нутагт оршин суудаг эсвэл бизнес эрхлэлдэг;
- ii. Хориотой улс/бүс нутагт оршин суугаа хувь хүмүүст борлуулалт хийдэг;
- iii. Хориотой улс/бүс нутагт байрлах аж ахуйн нэгж, эсвэл байнга оршин суудаг хувь хүний эзэмшдэг, хяналтад байдаг аж ахуйн нэгж;
- iv. АНУ-ын Сангийн яамны Гадаад хөрөнгийн хяналтын албаны жагсаалтад орсон хэн нэгний эзэмшдэг, хяналтад байдаг, энэ байгууллагын тусгайлан боловсруулсан жагсаалтад орсон аливаа хувь хүн, аж ахуйн нэгж.

# 9 Хэрхэн биеэ авч явах тухай үндсэн дүрэм

## 9.1 Холбогдох хууль тогтоомж, дүрмийг дагаж мөрдөх

Гишүүд үйл ажиллагаа явуулж буй улс орон бүрийн үндэсний болон орон нутгийн бүх хууль журам (үүнд дүрэм, журам, захирамж, лицензийн шаардлагууд зэрэг орно) болон Herbalife-ын дүрмийг дагаж мөрдөх ёстой бөгөөд бусад хүмүүсийг эдгээр дүрмийг зөрчихийг уриалж болохгүй.

Herbalife-ын дүрэм, хууль хоёрын хооронд зөрчил гарвал хууль үйлчилнэ.

Гишүүд Herbalife-ын бизнесээ явуулахдаа ашигладаг гуравдагч талын үйлчилгээний нөхцөлийг дагаж мөрдөх ёстой.

## 9.2 Herbalife-т үнэн зөв мэдээлэл өгөх ба харилцах

Гэрээ, маягт, баримт, бизнесийн бүртгэл ба/эсвэл татварын мэдээлэл, холбоо барих мэдээлэл, захиалгын мэдээлэл зэрэг Herbalife-д өгөх бүх мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд бөгөөд цаг тухайд нь өгөх ёстой.

## 9.3 Herbalife-ын нэр хүнд ба имижийг хадгалах

Гишүүд Herbalife-ын нэр хүнд, имиж, бүтээгдэхүүн, оюуны өмчид хохирол учруулж болохгүй.

## 9.4 Дарамт, ялгаварлан гадуурхалт, зүй бус үйлдлийн хувьд баримтлах дүрэм

Herbalife нь ямарваа нэг дарамт шахалт үзүүлэх, хууль бусаар ялгаварлан гадуурхах, зүй бусаар харилцах болон ёс бус үйлдэл хийхийг хориглодог.

## 9.5 Herbalife-ын байр суурийг дагаж мөрдөх

Гишүүд Herbalife-ын байр суурийг эрхэмлэн ажиллах ёстой.

## 9.6 Өрсөлдөөний эсрэг үйлдэл хийхгүй байх

Гишүүд нь бие даасан бизнес эрхлэгчид бөгөөд бусад гишүүдтэй дараах асуудлаар гэрээ байгуулах ёсгүй:

- Herbalife®-ын бүтээгдэхүүнийг борлуулах үнэ;
- борлуулах нутаг дэвсгэр;
- түгээх арга; эсвэл
- Хэрэглэгч, Давуу эрхтэй үйлчлүүлэгч эсвэл Гишүүдийг хуваарилах.

## 9.7 Тоглоомт промоушен

Гишүүд Herbalife-ын бизнестэй холбоотойгоор лотерей эсвэл хонжворт сугалаа зохион байгуулж болохгүй. "[Сорилт ба тоглоомт урамшууллын удирдамжийг](#)" дагаж мөрдөж буй тохиолдолд дэмжих бүлэг, биеийн өөрчлөлтийн сорилт, багийн борлуулалтын промоушен, марафон, азтан тодруулах зэрэг бусад тоглоомт промоушеныг зөвшөөрч болно.

## 10 Захиргааны хэсэг

### 10.1 Гишүүнчлэлийн эрх авахад тавигдах шаардлага

#### 10.1.1 Гишүүнчлэлийн эрх авах насны доод хязгаар

Гишүүнчлэлийн эрх авах хүсэлт гаргах болон Herbalife компанийн өөр Гишүүний бизнест оролцох хүн 18 нас хүрсэн байна.\*

\* Насны доод хязгаарын шаардлага улс орон бүрд харилцан адилгүй байдаг. Бусад улс орны насны доод хязгаарын шаардлагатай танилцахыг хүсвэл Мэдээлэл харилцааны албанд хандана уу.

#### 10.1.2 Гэр бүлийн хүн эсвэл Хамтран амьдрагчийг бүртгэлд нэмж оруулах

Гишүүн нь өөрийн гэр бүлийн хүн буюу эсвэл хамтран амьдрагчаа Гишүүнчлэлийн эрхийн бүртгэлд нэмж оруулж болох ба бүртгэлд ийнхүү нэр нэмж оруулах нь тэднийг бизнест дэмжих ба сайшаалын\* зорилготой.

Гишүүнд нь баримт бичгүүд дээр өөрийн статусаа хадгалж үлдэнэ. Гэхдээ эхнэр/нөхөр эсвэл хамтран амьдрагчаасаа салсан тохиолдолд Гишүүнчлэлийг өмчлөх эрх болон үүнтэй холбоотой бусад эрхэд нөлөөлж болно\*\*.

\* Жишээлбэл, албан ёсны бүртгэл нь Herbalife компанийн арга хэмжээнд оролцох, шинэ бизнесийг хүлээн зөвшөөрөх, Маркетингийн төлөвлөгөөнд гаргасан амжилтыг үнэлж сайшаах боломж олгодог.

\*\* Эхнэр/нөхөр/хамтран амьдрагчаасаа салсан тохиолдолд, гэрээнд эхнэр/нөхөр/хамтран амьдрагч бүртгэгдсэн байгаа эсэх нь шүүхийн шийдвэрт нөлөөлж болно.

### 10.2 Гишүүнчлэлийн эрхийг шилжүүлэх

#### 10.2.1 Гишүүнчлэлийн эрхийг шилжүүлэх, худалдах, дамжуулах

Herbalife компаниас Herbalife компанийн бүрэн эрх, үзэмжийн хүрээнд дангаар шийдвэрлэн, урьдчилан бичгээр гаргаж өгсөн зөвшөөрөлгүйгээр Гишүүнчлэлийн эрхэд хамаарах аливаа эрх, эзэмшлийн эрхийг шилжүүлэх, худалдахыг зөвшөөрөхгүй.

Дүрмүүдээс буюу хууль тогтоомжоос зайлсхийхийн тулд аливаа Гишүүн Гишүүнчлэлийн эрхээ шилжүүлж болохгүй. Хэрвээ Herbalife компани эрх шилжүүлэх тухай хүсэлтийг зөвшөөрснийхөө дараа хуучин Гишүүн (Эрх шилжүүлэгч) болон/эсвэл Эрх шилжүүлэгчийн гэр бүлийн хүн эсвэл хамтран амьдрагч Дүрмүүдийг зөрчсөн гэж тооцогдох байдлаар биеэ авч явсан эсвэл Дүрмүүдийг зөрчсөн гэж тооцогдох үйл ажиллагаанд оролцсон болохыг олж мэдвэл Herbalife компани шилжүүлсэн Гишүүнчлэлийн эрхэд хариуцлага ногдуулж болно.

#### 10.2.2 Гишүүнчлэлийн эрхийг зөвхөн Herbalife-ын гишүүн бус хүнд борлуулж, дамжуулах буюу шилжүүлж болно

Өв залгамжлах дүрмээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Гишүүнчлэлийн эрхийг зөвхөн Гишүүн бус хувь хүнд борлуулах, шилжүүлэх буюу дамжуулж болно. Хэрэв хүсэлт гаргагч нь Идэвхгүй байх хүлээлтийн хугацааны шаардлагыг хангаагүй бол Herbalife компани нь Гишүүн болгохоор санал болгож буй хүний (Эрх шилжүүлэн авч буй хүн) Гишүүнчлэлийн эрх шилжүүлэх хүсэлтийг хүлээж авахгүй. (Идэвхгүй байх хугацаатай холбоотой дүрмийг харна уу).

#### 10.2.3 Шатлал, статус, эрх, хөнгөлөлт

Гишүүний ололт амжилт нь тухайн хүний хувийн амжилт тул Гишүүний эрхийг зөвшөөрөлтэйгөөр бусдад борлуулах, шилжүүлэх буюу дамжуулахад тухайн Гишүүний шатлал, статус болон эрх, хөнгөлөлт Гишүүнчлэлийн эрхтэй хамт шилжихгүй.

Эрх шилжүүлэн авсан хүндээ шилжүүлэх эсвэл дамжуулах ажиллагаа дууссаны дараа шатлал болон орлоготой холбоотой бүх болзол, шалгуурыг биелүүлэхийг тухайн этгээдээс шаардаж болно. Эдгээр шаардлагад Супервайзорын шатлал, статус, TAB Team гишүүний шатлал, статус, амралт эдлэхэд тавигдах болзол шалгуур, эсвэл тухайн хувь Гишүүний аливаа бусад эрх хамаарна.

#### 10.2.4 Эрх шилжүүлсний дараах хариуцлага


Гишүүнчлэлийн эрхийг шилжүүлсний дараа:

- Гишүүнчлэлийн эрхтэй холбоотой Эрх шилжүүлэгч өөрөө буюу эсвэл түүний өмнөөс өөр этгээд үйлдсэн Дүрэм зөрчсөн бүх үйлдэлд Herbalife компанийн өмнө Эрх шилжүүлэн авсан хүн хариуцлага хүлээнэ.
- Гишүүнчлэлийн эрхийг хүчин төгөлдөр шилжүүлсэн өдрөөс хойш 6 сарын хугацаанд, хэрэв эрх Шилжүүлэгч нь Гишүүн хэвээр байгаа тохиолдолд, Эрх шилжүүлэгч, түүний гэр бүлийн хүн, хамтран амьдрагч нь Дүрэм зөрчсөн гэж тооцогдох аливаа үйлдэл гаргасан бол Эрх шилжүүлэн авсан хүн нь тухайн зөрчлийг гаргасан гэж тооцогдоно.

### 10.3 Хамтран амьдрагчаасаа тусдаа амьдрах, салах, харилцаагаа цуцлах

#### 10.3.1 Шинэ гишүүнчлэл үүсгэх

Хэрэв гишүүний эхнэр, нөхөр эсвэл хамтран амьдрагч нь гэр бүл цуцлуулах явцад эсвэл гэр бүл цуцалсны дараа эсвэл хамтран амьдрагчийн харилцаагаа дуусгавар болгосон даруйд Herbalife-ын бизнест үргэлжлүүлэн ажиллахыг хүсвэл гишүүн болон эхнэр/нөхөр/хамтран амьдрагч нь анхны гишүүнчлэлийн спонсорын дор тус тусдаа шинэ гишүүнчлэлийг эхлүүлэх ёстой. Herbalife нь анхны гишүүнчлэлийн худалдан авах эрхийг хүчингүй болгож, анхны гишүүнчлэлийн бизнесийн үйл ажиллагааг "Хамтын ажиллагаа" хэмээх аргаар дамжуулж шинээр үүссэн тус бүрийг гишүүнчлэл рүү шилжүүлнэ. (Хамтран амьдрагчаасаа салах, харилцаагаа цуцлах тухай болон Herbalife-ын Борлуулалт ба маркетингийн төлөвлөгөөг үзнэ үү). Бүх гишүүд өөрийн ID дугаарыг бизнестээ ашиглах шаардлагатай.



Гишүүн болон салсан эхнэр, нөхөр/хамтран амьдрагч нь үндсэн гишүүнчлэл болон түүний доод багийг хоорондоо хуваах боломжгүй юм. Жишээлбэл, хүн тус бүр үндсэн гишүүнчлэлийн 50%-ийг эзэмших замаар "хуваах" боломжгүй.

Herbalife-ын шинэ гишүүнчлэлд бүртгүүлэхийн тулд та дараах бичиг баримтыг бүрдүүлэх ёстой:

#### Гэр бүл цуцлуулсан бол:


- Гишүүн болон салсан эхнэр/нөхөр хоёр хоёул үндсэн гишүүнчлэлийн спонсорын дор тус тусдаа шинээр гэрээ бөглөж, гарын үсэг зурна.
- Гэр бүл цуцлуулж, салсан тухай гарын үсэг зурж баталгаажуулсан маягт.
- Гэр бүл цуцлуулсан тухай хууль ёсны гэрчилгээ эсвэл гэрлэлт цуцалсан эцсийн шийдвэрийн хуулбар.
- TAB Team-ийн гишүүдийн үйлчилгээ үзүүлсний урамшуулал хүлээн авах маягтыг бөглөж, Гишүүн болон салсан эхнэр/нөхрийн шинэ гишүүнчлэлийн ID дугаарыг тусгаж, гарын үсэг зурна (зөвхөн TAB Team-ийн гишүүд).

#### Хамтран амьдрагчаасаа харилцаагаа цуцалсан бол:

- Гишүүн болон харилцаагаа цуцлуулсан хамтран амьдрагч хоёр хоёул үндсэн гишүүнчлэлийн спонсорын дор тус тусдаа шинээр гэрээ бөглөж, гарын үсэг зурна.
- Хамтран амьдрагчийн харилцааг цуцлах маягтад хоёр тал гарын үсэг зурж, баталгаажуулсан байна. (Хэрэв хоёр тал гарын үсэг зурж, баталгаажуулсан маягт ирүүлээгүй бол хоёр (2) гэрчээр баталгаажуулсан эд хөрөнгийн харилцааг цуцлах маягт шаардагдана.)

- ТАВ Team-ийн гишүүдийн үйлчилгээ үзүүлсний урамшуулал хүлээн авах маягыг бөглөж, Гишүүн болон харилцаагаа цуцалсан хамтран амьдрагчийн шинэ гишүүнчлэлийн ID дугаарыг тусгаж, гарын үсэг зурна (зөвхөн ТАВ Team-ийн гишүүд).


Гишүүн дахин гэрлэсэн эсвэл шинэ хамтран амьдрагчтай болсон тохиолдолд шинэ эхнэр/нөхөр эсвэл хамтран амьдрагч нь Гишүүний бизнест оролцох, хамт сайшаал хүртэх зорилгоор тус гишүүний шинээр тусдаа үүсгэсэн гишүүнчлэлд нэрээ нэмж оруулах боломжтой.




**Нэгээс олон удаа гэр бүлээ эсвэл харилцаагаа цуцлуулсан бол:**

Herbalife нь зөвхөн нэг удаа гэр бүл эсвэл харилцаагаа цуцалсан гишүүнчлэлийг авч үзэх болно. Нэгээс олон удаа гэр бүл эсвэл харилцаагаа цуцалсан тохиолдолд салсан эхнэр/нөхөр/хамтран амьдрагч нь тусдаа гишүүнчлэл үүсгэж болох боловч өөр гишүүнчлэлтэй ямар нэг холбоогүй байх болно.

Жишээлбэл, хэрэв Боб, Барбара хоёр салсан бол Барбара анхны гишүүнчлэлийн спонсорын дор шинээр тусдаа гишүүнчлэл (“D”) үүсгэж болох ч энэ нь Бобын гишүүнчлэлтэй (“C”) холбоогүй байна.



Борлуулалт ба маркетингийн төлөвлөгөөний дагуу Барбарагийн шинэ гишүүнчлэлийн түвшнийг (“D”) өмнөх гишүүнчлэлийн (“C”) хүрээнд бий болгосон бизнесийн үйл ажиллагаанд үндэслэн тогтооно. Жишээлбэл, өмнөх гишүүнчлэлийн (“C”) бизнесийн үйл ажиллагаа нь GET Team-ийн түвшний орлого хүртдэг тул Барбарагийн шинэ гишүүнчлэл (“D”) нь GET Team-ийн түвшинд байгуулагдах болно.



**10.3.2 Анхны гишүүнчлэлд өөрчлөлт оруулах хүсэлт**

Herbalife нь анхны гишүүнчлэлд өөрчлөлт оруулах хүсэлтийг хүлээн авна. Herbalife нь гэр бүл цуцлуулах шүүхийн эцсийн шийдвэрийн баталгаажуулсан хуулбарыг хүлээн аваагүй тохиолдолд хоёр талын гарын үсгээр баталгаажсан өргөдлийн маягыг хүлээн авна.

**Эхнэр/нөхөр эсвэл хамтран амьдрагчийн нэрийг хасах:** Herbalife-ын Гишүүнчлэлийн бүртгэлээс эхнэр, нөхөр эсвэл хамтран амьдрагчийн нэрийг хасуулахын тулд эхнэр/нөхрөө хасуулах хүсэлтийн маягт эсвэл хамтран амьдрагчаа хасуулах хүсэлтийг маягыг бөглөж Herbalife-д өгөх шаардлагатай.

**Төлбөр:** Төлбөр төлөлтөд өөрчлөлт оруулахын тулд Төлбөрийн хүсэлтийн маягыг бөглөж Herbalife-д өгөх ёстой. Дараа дараагийн хүсэлтүүдэд хоёр тал гарын үсэг зурж, нотариатаар батлуулсан байх ёстой. Үндсэн гишүүнчлэлийн орлогын мэдүүлгийг [MyHerbalife.com](http://MyHerbalife.com) сайтад үндсэн гишүүнчлэлийн ID дугаараар нэвтэрч авах боломжтой.

**Шилжүүлэг:** Гишүүн бус салсан эхнэр/нөхөр, хамтран амьдрагчид гишүүнчлэлийг шилжүүлэхийн тулд Гэр бүл цуцлах маягт эсвэл хамтран амьдрагчийн харилцаагаа цуцлах маягыг бөглөж Herbalife-д өгөх ёстой.

Хэрэв шилжүүлэх гишүүнчлэл өөр гишүүнчлэлтэй холбоотой бол шилжүүлсэн гишүүнчлэл нь холбоотой хэвээр байх болно.

### **Гишүүн гишүүнчлэлээ шилжүүлсний дараа шинээр гишүүнчлэл байгуулахаар шийдсэн бол:**

- Шинэ гишүүнчлэл нь анхны гишүүнчлэлээсээ хараат бусаар ажиллах ёстой.
- Борлуулалт ба маркетингийн төлөвлөгөөний дагуу шат ахих, үйлчилгээний үзүүлсний урамшуулал, нэмэлт үйлчилгээний үзүүлсний урамшуулал болон бусад орлогыг зөвхөн шинэ гишүүнчлэлийн ололт амжилтад үндэслэнэ.

### **Herbalife-ын зүгээс шинэ гэрээг зөвшөөрөхийн тулд:**

- Гишүүн нь Супервайзор ба түүнээс доош статустай бол шилжүүлэг хийснээс хойш нэг жилийн дотор, харин World Team ба түүнээс дээш статустай бол шилжүүлэг хийснээс хойш хоёр жилийн дотор хүсэлтээ гаргах ёстой.
- Үндсэн гишүүнчлэлийн спонсор нь шинэ гишүүнчлэлийг спонсорлох ёстой.
- Шинэ гишүүнчлэлийн статус нь шилжүүлэг хийх үеийн өмнөх гишүүнчлэлийн статустай ижил байх болно.

### **10.3.3 Өөр спонсорын багт орох/өөр гишүүнчлэлд оролцох**

Өөр спонсорын багт орохын тулд гишүүн эсвэл түүний эхнэр/нөхөр/хамтран амьдрагч нь дараах шаардлагатай бичиг баримтыг Herbalife-д өгөх ёстой:\*

#### **Гэр бүл цуцлуулсан бол:**

- Шинээр бөглөж, гарын үсэг зурсан Гэрээ.
- Гэр бүл цуцлуулах, салах маягтад гарын үсэг зурж, гэрчээр баталгаажуулсан байна.
- Гэр бүл цуцлуулсан тухай хууль ёсны гэрчилгээ эсвэл гэрлэлт цуцалсан эцсийн шийдвэрийн хуулбар эсвэл гэр бүлийн харилцаа дуусгавар болсон тухай түр зуурын шийдвэр гаргасан шүүхийн баримт бичиг.

#### **Хамтран амьдрагчийн харилцаагаа цуцалсан бол:**

- Шинээр бөглөж, гарын үсэг зурсан Гэрээ.
- Хамтран амьдрагчийн харилцааг цуцлах маягтад хоёр тал гарын үсэг зурж, баталгаажуулсан байна. (Хэрэв хоёр тал гарын үсэг зурж, баталгаажуулсан маягт ирүүлээгүй бол хоёр (2) гэрчээр баталгаажуулсан эд хөрөнгийн харилцааг цуцлах маягт шаардагдана.)

Нэмж дурдахад, гишүүн эсвэл эхнэр/нөхөр эсвэл хамтран амьдрагч нь идэвхгүй байх хугацааг баримтлах ёстой. Идэвхгүй байх хугацааг "идэвхгүй байх хугацааны дүрэм"-д заасанчлан эсвэл шүүхээс хүлээн авсан баримт бичгийг гаргасан огноогоор тодорхойлно.

Тайлбар: Өөр спонсорын дор шинэ гишүүнчлэл байгуулахад шинэ гэрээ худалдан авах шаардлагатай бөгөөд 25%-ийн хөнгөлөлттэй эхлэх ба шинэ гэрээ нь өмнөх гишүүнчлэлтэй ямар нэг байдлаар огт холбоогүй байх болно.

\* Мэдээлэл харилцааны албанаас авах боломжтой маягт ба өргөдлийн хуудаснууд.

### **10.3.4 Гэр бүл салалт, хамтран амьдрагчийн харилцаа дуусгавар болох болон Herbalife-ын Борлуулалт ба маркетингийн төлөвлөгөө**

**Нийт оноо:** үндсэн гишүүнчлэл дээрх оноог хувь хүний гишүүнчлэл дээрх оноотой хамтруулж тооцно ("Хамтын үйл ажиллагаа"). Энэ оноонд үндэслэж үйлчилгээ үзүүлсний урамшуулал, болзол, давтан баталгаажилт ба/эсвэл үйлчилгээ үзүүлсний нэмэлт урамшуулал зэргийг тодорхойлно.

Үйлчилгээ үзүүлсний урамшууллын хувийг тооцоход анхны гишүүнчлэл дээрх оноог хувь хүн тус бүрийн гишүүнчлэл дээрх онооны хамт тооцно.

Үндсэн гишүүнчлэлийн үйлчилгээ үзүүлсний урамшууллыг хамгийн өндөр амжилттай байгаа аль нэг гишүүнчлэлд үндэслэн тодорхойлно.

Жишээ:

Оноо

В ба С-ийн оноо дараах байдалтай байна:


В + А болон С + А



Үйлчилгээ үзүүлсний урамшууллын оноо

Үйлчилгээ үзүүлсний нэмэлт урамшууллын оноог дараах байдлаар нэгтгэнэ:

В + А ба С + А



**Тавигдах шаардлага:** Гишүүнчлэл бүр нь 10 жижиглэнгийн хэрэглэгчийн дүрэм, 70%-ийн дүрэм болон үйлчилгээ үзүүлсний урамшуулал авах бусад шаардлагыг биелүүлэх ёстой.

Гишүүн бүр доод багийнхаа Супервайзор болох эрхтэй гишүүдийн хувьд "Matching Volume" буюу "Тэнцүүлэх онооны" шаардлагыг биелүүлэх ёстой. Үндсэн гишүүнчлэлийн хувьд доод багийн "Тэнцүүлэх онооны" шаардлагыг хангахын тулд худалдан авах эрхийг нь түр хугацаанд олгоно.

**Сайшаал:** Гишүүнчлэл бүрийг Борлуулалт ба маркетингийн төлөвлөгөөний дагуу ололт амжилтаар нь үнэлэн сайшаана. Үндсэн гишүүнчлэл нь сайшаагдахгүй. Үндсэн болон хувь гишүүнчлэл нь President's Team-ийн түвшинд хүрсэн тохиолдолд дээрх President's Team-ийн гишүүнд зөвхөн нэг бриллиантыг олгох бөгөөд энэ нь гэр бүл цуцлалт эсвэл хамтран амьдрагчийн харилцааг дуусгавар болгоогүй Гишүүнчлэлд зориулсан бриллиантын хуваарилалтад нийцэх юм. Хэрэв хувь гишүүнчлэл нь бриллиантын болзол хангасан бол зөвхөн тухайн гишүүнчлэл нь бриллиантын статус хүртэх болно.

**Арга хэмжээ:** Арга хэмжээнд оролцохтой холбоотой дүрэм журам нь арга хэмжээ тус бүрд хамаарах бөгөөд өөр өөр байж болно. Байр, тасалбар, унаа болон бусад арга хэмжээний дэлгэрэнгүй мэдээллийг арга хэмжээний материалаас авна уу.

#### 10.4 Өв залгамжлах\*

Гишүүн нас барвал түүний Гишүүнчлэлийн эрхийг холбогдох хууль тогтоомж, дүрмүүд болон Herbalife компанийн зөвшөөрлийн дагуу өв залгамжлагчид нь шилжүүлж болох ба үүнийг шалтгаангүйгээр нуун дарагдуулж болохгүй\*\*.

Гишүүн нь өөрийнхөө Гишүүнчлэлийн эрхээс гадна өв залгамжлалаар хоёр хүртэлх тооны Гишүүнчлэлийн эрхийг шилжүүлэн авах замаар дээд тал нь гурван Гишүүнчлэлийн эрх эзэмшиж, хэрэгжүүлж болно.

Өв залгамжлан авсан Гишүүний эрхийг өв залгамжлагч хувь хүнд эсвэл TAB Team түвшний статус бүхий Гишүүний эрхийн тухайд, өв залгамжлагчийн эзэмшдэг Корпорацад\*\*\* шууд шилжүүлж болно.\*\*\*\*

Өв залгамжлагдсан гишүүнчлэлийн идэвхгүй байх хугацаа (Идэвхгүй байх үеийн дүрэмд заасан) хүчингүй болно.

Өв залгамжлагч нь Herbalife дангаараа, бүрэн эрхийнхээ хүрээнд шаардсан бүх баримт бичгүүдийг хангаж өгөх ёстой.

Нас барсан Гишүүний Гишүүнчлэлийг цуцлахын тулд Мэдээлэл харилцааны албанд шууд хандана уу.

\* Үл хөдлөх хөрөнгийн төлөвлөлт, өв залгамжлалын хувьд Бизнесийг үргэлжлүүлэх хөтөлбөр нь гишүүнчлэлээ тасралтгүй хэрэгжүүлэхэд туслах боломжтой. Нэмэлт мэдээлэл авахын тулд Мэдээлэл Харилцааны аралбанд хандах эсвэл [MyHerbalife.com](http://MyHerbalife.com) сайтаар нэвтрэн «Herbalife компанийн Гишүүний - Хэтийн төлөвлөгөө» хэсэгтэй танилцана уу.

\*\* Өв залгамжлуулах талаарх мэдэгдлийн маягтын загварыг Мэдээлэл харилцааны албанд хандаж авна уу.

\*\*\* Өв залгамжлагчийн оршин сууж буй улсын хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бол.

\*\*\*\* Өв залгамжлан авсан Гишүүнчлэлийн эрхүүдийг тусдаа нэгжүүд гэж үзэх бөгөөд тус бүртээ Борлуулалт, маркетингийн төлөвлөгөөнд заасны дагуу бизнесийн үйл ажиллагаагаа явуулж, борлуулалтын оноо цуглуулж, нөхөн олговрын талаарх нөхцөл болзлыг биелүүлэх ёстой. Өв залгамжлагчийн өөрийн нийт оноог өв залгамжлан авсан Гишүүний эрхэд хамаарах нийт оноотой нийлүүлж тооцохыг зөвшөөрдөг насан туршийн онооны болзлыг хангах явдал үүнд хамаарахгүй. Өв залгамжлагч нь эзэмшиж буй Гишүүнчлэлийн эрх нэг бүрийн хураамж, өрийг хариуцан төлөх ёстой.

#### 10.5 Үйл ажиллагаагаа зогсоох

Гишүүн нь [MyHerbalife.com](http://MyHerbalife.com) дээрх Онлайн туслахаар дамжуулан үйл ажиллагаагаа зогсоох хүсэлтээ илгээх эсвэл Мэдээлэл Харилцааны Албанд гарын үсэг зурсан хүсэлтийг бичгээр өргөн мэдүүлэх замаар гишүүнчлэлээсээ татгалзаж болно. Herbalife компани тухайн хүсэлтийг хүлээн авч, зөвшөөрсөн тохиолдолд Гишүүний үйл ажиллагааг зогсоох үйл явц хүчин төгөлдөр болно.

#### 10.6 Хэрэглэгчдэд борлуулалт хийх

Herbalife нь бие даасан гэрээ байгуулагчдаараа (Гишүүд) дамжуулан, үйлчлүүлэгчдэд Herbalife -ын бүтээгдэхүүнүүдийг шууд борлуулж, тэдэнд бүтээгдэхүүний зааварчилгаа өгч, хамт олны хүрээлээр дэмжлэг үзүүлдэг шууд борлуулалтын компани юм.

#### 10.7 Бизнесийн бүртгэл, татвар

Дүрмүүд болон бусад шаардлагууд нь улс орон бүрд харилцан адилгүй байдаг бөгөөд байнгын өөрчлөгдөж шинэчлэгддэг. Үүнд:

- бизнесийн бүртгэлийн горим;
- НӨАТ (мэдээллийн хангалт, цуглуулалт, нягтлан бодох бүртгэл, тайлан);
- бусад татвар.

Herbalife компанийн бизнесийг эрхлэхдээ офлайн эсвэл онлайнээр борлуулж буйгаас үл хамааран бизнесийн бүртгэл, лиценз, татвар, тайлангийн бүх дүрэм журмыг дагаж мөрдөх ёстой. Хэрэв Та онлайн платформоор дамжуулан бүтээгдэхүүнээ борлуулж байгаа бол хууль эрх зүйн болон тайлангийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгах нь зүйтэй.

Herbalife компанийн дүрмийн дагуу Гишүүд нь өөрийн бизнесийн бүртгэл болон татварын бүртгэлийн мэдээллээ компанид мэдэгдэж байх ёстой бөгөөд өмнө нь өгсөн мэдээлэлдээ гаргасан өөрчлөлтийг цаг алдалгүй мэдээлэх ёстой.

## 10.8 Төлбөр урамшуулал ба дахин тооцоолол

Herbalife компаниас санал болгосон сар тутмын Үйлчилгээ үзүүлсний урамшуулал, Үйлчилгээ үзүүлсний нэмэлт урамшуулал болон бусад бонусын болзлыг хангахын тулд Гишүүд нь [Борлуулалт ба маркетингийн төлөвлөгөө](#), бусад хэвлэмэл материал, сурталчилгааны материалд дэлгэрэнгүй тодорхойлсон борлуулалтын бүтээмж болон Үйлчилгээ үзүүлсний урамшууллын онооны шаардлагуудыг хангах ёстой. Мөн эдгээр төлбөрийн болзлыг хангахын тулд Гишүүд нь жижиглэн худалдааны үйлчлүүлэгчид болон бүтээгдэхүүн түгээлтийн талаарх тодорхой шаардлагуудыг хангаж, энэ тухайгаа [Орлогын гэрчилгээний маягтаар](#) баталгаажуулах\* ёстой. Маягтыг тухайн сарын үйл ажиллагаанд хамаарч тухайн сарын эцэст Herbalife-д илгээсэн байх ёстой.

\* [Орлогын баталгаажилтын маягтыг](#) [MyHerbalife.com](#) хаягаар орж авч болно.

## 10.9 Спонсорын эгнээг хамгаалах, хадгалах

Гишүүн/Спонсорын харилцаа нь [Борлуулалт, Маркетингийн Төлөвлөгөөний](#) тулгуур үндэс юм. Энэхүү Дүрмээр гишүүн болон спонсор талуудыг аль алиныг нь хамгаалдаг бөгөөд үүнд спонсорын эрхийг хамгаалах явдал мөн багтдаг. Гишүүдийг спонсорлож буй Спонсорууд өөрийн доод үеийн гишүүдийг дэмжихийн тулд цаг хугацаа, хүчин чармайлт, манлайлах чадвараа ихээхэн зарцуулахын зэрэгцээ сургалт явуулдаг. Спонсорын эгнээнд өөрчлөлт оруулах нь Herbalife-ын бизнесийн нэгдмэл чанарт хор хохирол учруулна гэж үздэг тул ийм үйлдлийг дэмждэггүй. Гагцхүү ховор тохиолдолд үүнийг зөвшөөрдөг бөгөөд Herbalife компани өөрийн бүрэн эрх, үзэмжийн хүрээнд дангаар шийдвэрлэдэг.

### 10.9.1 Спонсор өөрчлөх

Спонсороо өөрчлөх хүсэлт гаргах Гишүүн нь “Спонсороо өөрчлөх тухай хүсэлт”-ийн маягтыг\* бөглөн, хуучин Спонсорын үйлдсэн “Спонсор өөрчлөх зөвшөөрөл”, болон санал болгож буй Спонсорын үйлдсэн зөвшөөрсөн захидлын хамтаар өргөн мэдүүлнэ. Бүх бичиг баримтуудыг 2 гэрчийн гарын үсгээр баталгаажуулсан байх шаардлагатай.

Зөвхөн дараах бүх шаардлагууд хангагдсан үед Спонсор өөрчлөх хүсэлтийг хянан үзнэ. Үүнд:

- Гэрээн дээр өгсөн Спонсорын талаарх мэдээлэл алдаатай байсан.
- Энэхүү хүсэлтийг Herbalife компани Гэрээг хүлээн авснаас хойш 90 хоногийн дотор гаргасан.
- Одоогийн болон санал болгож буй Спонсор нь нэг эгнээнд байгаа.
- Одоогийн Гишүүнчлэлийн эрх нь Супервайзорын түвшинд хүрээгүй.
- Хүсэлт гаргаж буй Гишүүн одоогоор өөр Гишүүн спонсорлодоггүй.

\* *Шаардлагатай “Спонсороо өөрчлөх тухай хүсэлт”-ийн маягтыг болон “Спонсор өөрчлөх зөвшөөрөл”-ийн маягтыг Мэдээлэл Харилцааны Албанаас авч болох бөгөөд хүсэлтийг Herbalife компанид хянуулахын тулд эдгээр маягтууд болон заасан бусад баримт бичгийг Herbalife-ын Мэдээлэл Харилцааны Албанд өргөн мэдүүлнэ.*

*Нотариатаар баталгаажуулахын оронд Бие даасан гишүүн бүр өөрийн бөглөж, гарын үсэг зурсан маягтуудаа MyHerbalife.com > Онлайн туслахаар дамжуулан илгээж болно.*

*Вьетнам улсын хувьд бүх хүсэлтийн маягтыг нотариатаар баталгаажуулсан байх ёстой. Нотариатаар баталгаажуулаагүй имэйлээр ирүүлсэн материалыг хүлээн авахгүй.*

## 10.9.2 Спонсороо өөрчлөх хүсэлт гаргах

**Олон шатлалт маркетингийн бизнесийн тулгуур зарчим болсон багийн нэгдмэл чанарыг хамгаалах үүднээс спонсороо сольж өөрчлөх явдлыг Herbalife компани дэмждэггүй бөгөөд ийм хүсэлтийг зөвхөн онцгой тохиолдолд зөвшөөрөх болно.**

Спонсор өөрчлөх хүсэлтийг зөвхөн өөрийн багийн дээд үеийн President's Team /Президент баг хүртэл өөрчлөх боломжтой.

Спонсороо өөрчлөхийг хүсч буй Гишүүн нь эхлээд нөхцөл байдлыг Спонсортойгоо хэлэлцэж зөвлөлдөх хэрэгтэй. Хэрэв хүсэлтийг үргэлжлүүлэхээр бол "Спонсор өөрчлөх хүсэлт\*" -ийн маягыг бөглөж, 2 гэрчийн гарын үсгээр баталгаажуулна, мөн өөрийн одоогийн Спонсор, Үйлчилгээ үзүүлсний урамшуулал болон 7%-ийн Үйлчилгээ үзүүлсний нэмэлт урамшуулал авдаг дээрх President's Team хүртэлх бүх гишүүдийг оролцуулан 2 гэрчийн гарын үсгээр баталгаажуулсан "Спонсор өөрчлөх зөвшөөрөл" -ийн маягтын хамтаар мэдүүлэн өгөх ёстой. Үүнээс гадна шинэ спонсорын гарын үсэг бүхий "Спонсор өөрчлөх зөвшөөрлийн" маягыг 2 гэрчийн гарын үсгээр баталгаажуулж Herbalife-д өгөх ёстой.

Хэрэв одоогийн болон шинээр санал болгож байгаа Спонсорын аль аль нь дээрээ адил Спонсортой бөгөөд Борлуулалт ба маркетингийн төлөвлөгөөний дагуу статус, шатлал болон орлогын түвшин нь адил бол спонсороо солих хүсэлт гаргаж буй Гишүүн зөвхөн одоогийн Спонсоруудаас 2 гэрчийн гарын үсгээр баталгаажуулсан "Спонсор өөрчлөх зөвшөөрөл" -ийн маягтаар үйлдсэн зөвшөөрлийг шинээр санал болгож буй Спонсороос 2 гэрчийн гарын үсгээр баталгаажуулан авах хэрэгтэй юм.

Хэрэв Herbalife компаниас спонсор солих хүсэлтийг зөвшөөрвөл хүсэлт гаргаж буй Гишүүн доод үеийн багаа авч үлдэхийг зөвшөөрөхгүй.

Хэрэв спонсороо солих хүсэлтэд татгалзсан хариу өгсөн бол тухайн Гишүүн үйл ажиллагаагаа зогсоож, Хүлээлтийн хугацааны шаардлагыг хангасны дараа өөр Спонсорын удирдлага дор Гишүүнчлэлийн эрх авах хүсэлтийг Herbalife компанид дахин гаргаж болно. (Идэвхгүй байх хугацаатай холбоон дүрмийг үзнэ үү)

\* *Шаардлагатай "Спонсороо өөрчлөх тухай хүсэлт" -ийн маягыг болон "Спонсор өөрчлөх зөвшөөрөл" -ийн маягыг Мэдээлэл Харилцааны Албанаас авч болох бөгөөд хүсэлтийг Herbalife компанид хянуулахын тулд эдгээр маягтууд болон заасан бусад баримт бичгийг Herbalife -ын Мэдээлэл Харилцааны Албанд өргөн мэдүүлнэ.*

*Нотариатаар баталгаажуулахын оронд Бие даасан гишүүн бүр өөрийн бөглөж, гарын үсэг зурсан маягтуудаа MyHerbalife.com > Онлайн туслахаар дамжуулан илгээж болно.*

*Вьетнам улсын хувьд бүх хүсэлтийн маягыг нотариатаар баталгаажуулсан байх ёстой. Нотариатаар баталгаажуулаагүй имэйлээр ирүүлсэн материалыг хүлээн авахгүй.*

## 10.10 Дүрмийн хэрэгжилтийг хангах журам

Дүрмүүд нь Herbalife-ын боломж болон брэндийг хамгаалдаг. Зөрчлүүд нь Herbalife компани, түүний бүтээгдэхүүнүүд, түүний Гишүүдийн талаарх хууль тогтоогчдын, хэвлэл мэдээллийнхний болон олон нийтийн санаа бодолд сөргөөр нөлөөлж болно. Дүрмийн олон зөрчлүүдийг Биеэ Авч Явах Дүрэм болон бизнес үйл ажиллагаануудын талаар Гишүүдэд танин мэдүүлснээр шийдэх боломжтой хэдий ч илүү хатуу хариуцлага тооцох шаардлагатай Дүрмийн зөрчлүүд гардаг.

Herbalife компанийн болон Гишүүдийн нэр төрийг хамгаалах үүднээс Дүрэм зөрчсөн аливаа үйлдлийн талаар нэн даруй Herbalife компанид мэдээлэхийг Гишүүдэд зөвлөдөг. Herbalife компани нь Гишүүн мэдсэнээс хойш буюу мэдэх боломжтой байсан хугацаанаас хойш 1 жилийн дотор гаргаж тавьсан гомдлын мөрөөр ажиллах боловч дурын үед шалгалт явуулах эрхийг хадгална.\*

*\* Herbalife компаниас Дүрмийг хэрэгжүүлэх явдал нь алдсан орлогын, брэндийн үнэ цэнийг хөндсөн эсвэл ямарваа гарцаагүй хохирлуудыг барагдуулах үүрэг үүсгэхгүй.*

### 10.10.1 Гомдол гаргах журам

Гишүүд дүрмийн зөрчил гарсан байж болох талаарх мэдээллийг [MyHerbalife.com](http://MyHerbalife.com) дээрх Онлайн туслахаар дамжуулан Herbalife-д мэдэгдэх ёстой. Шаардлагатай мэдээлэлд гомдлын мөн чанар болон гомдлын талаар нотлох баримтууд багтана.\*

Гишүүд ямар нэгэн байдлаар үйлчлүүлэгч эсвэл гишүүнийг гомдол гаргах, хариу арга хэмжээ авахыг хориглож болохгүй.

*\* Бодит мэдээлэлд холбогдох хүмүүсийн нэр, хаяг, утасны дугаар, огноо, цаг, байршил гэх мэт орно.*

### 10.10.2 Шалгах явц

Хэрэв Herbalife компани өөрийн бүрэн эрх, үзэмжийн дагуу тухайн зөрчлийг нотлох баримт хангалттай байна гэж үзвэл Herbalife компанийн төлөөлөгч гомдолд холбогдох Гишүүнтэй холбоо барьж ирсэн гомдолтой холбоотой мэдээллийг танилцуулж, хариу тайлбар өгөх хугацааг Гишүүнд олгоно.

Зарим тохиолдолд шалгах явцад Гишүүнчлэлийн эрхэд тодорхой хязгаарлалт тавих шаардлага гарч болно. Энэхүү хязгаарлалтад Herbalife компанийн арга хэмжээнд оролцохыг хориглох, мөн доор дурдсан зүйлсийг түдгэлзүүлэх үйлдэл орж болно. Үүнд:

- Худалдан авалт хийх эрх.
- Үйлчилгээ үзүүлсний урамшууллын төлбөр.
- ТАВ Team-ийн урамшуулал.
- Шагнал, урамшуулал (амралт, тэмдэг гэх мэт).
- Herbalife компанийн ивээн тэтгэсэн сургалт семинар болон бусад хурал цуглаан дээр үг хэлэх.
- Хангаж буй болзол, баталгаажилт.
- Өөрийгөө Herbalife-ын Гишүүн хэмээн тодорхойлох эрх.

Herbalife нь зөрчил гаргасан Гишүүний нэр, гаргасан зөрчил, оноосон шийтгэлийг хэвлэн нийтлэх эцсийн шийдвэрийг Компани өөрийн үзэмжээр гаргана.

### 10.10.3 Авах арга хэмжээ

Гишүүний гаргасан зөрчлөөс болж Компанид эрхзүйн болон хууль дүрэмтэй холбоотой асуудал үүсэж болзошгүй бөгөөд бусад бүх Гишүүдийн бизнесийг эрсдэлд оруулж болзошгүй. Тиймээс тооцох хариуцлага өндөр байж болно.

Гарсан зөрчилд тохирох шийтгэлийг тогтоох эцсийн шийдвэрийг Herbalife компани өөрийн бүрэн эрх, үзэмжийн хүрээнд тухайн зөрчлийн мөн чанар болон үр дагаврыг харгалзан гаргах бөгөөд энэ нь доор дурдсан зүйлд хүргэсэн буюу хүргэж болох шийдвэр байна. Үүнд:

- Гишүүний бүх эрх, давуу эрхүүдийг түдгэлзүүлэх.
- Мөнгөн торгууль.
- Herbalife-ийн хууль ёсны төлбөрийг нөхөн төлөх үүрэг.
- Herbalife-ийн зохион байгуулсан арга хэмжээнүүдэд оролцох, үг хэлэхийг хориглох.
- Жил бүрийн Марк Хьюзийн нэрэмжит бонус урамшуулалд оролцох эрхийг хасах.
- Үйлчилгээ үзүүлсний нэмэлт урамшуулал хүртэх эрхийг хасах.
- Доод багаа бүрмөсөн алдах.
- Оноо болон орлогын дахин тооцоолол\*, болон/эсвэл
- Гишүүнчлэлийг цуцлах (доорх “Гишүүнчлэлийг цуцлах эсвэл устгах” тухай мэдээллийг үзнэ үү).

Хэрэв Herbalife бусад гишүүдийг тухайн зөрчилд тусалсан, уриалсан эсвэл оролцсон гэж дүгнэвэл эдгээр гишүүдэд зөрчлийн хариуцлагыг хүлээлгэж болно.

Herbalife нь зөрчил гаргасан гишүүний нэр, зөрчлийн баримт, нөхцөл байдал, авсан арга хэмжээг нийтлэх эрхтэй.

[\\* Оноо болон урамшууллын дахин тооцоолол гэдэгт Борлуулалт, маркетингийн төлөвлөгөөг үрвүүлэн ашигласан, хориотой байршлууд дээр борлуулалт хийсэн, цааш борлуулалт хийх зорилготой гишүүн бус хүнд бүтээгдэхүүн борлуулсан, дуудлага худалдааны сайт, гуравдагч этгээдийн онлайн худалдааны захуудаар борлуулалт хийсэн тохиолдлуудыг залруулах арга хэмжээ багтана.](#)

#### **10.10.4 Дахин хянан үзэх тухай хүсэлт (Гишүүнчлэлийн эрх цуцалсантай холбоогүй)**

Бие даасан гишүүн нь шийдвэр гарснаас хойш ажлын 7 өдрийн дотор Herbalife-ын шийдвэрийг дахин хянан үзэх хүсэлт гаргаж болно. Дахин хянан үзэх хүсэлт гаргахдаа Гишүүн нь нэмэлтээр авч үзэх шаардлагатай гэж үзэж буй нэмэлт мэдээлэл баримтыг өгч болох бөгөөд шалгалтын явцад яагаад уг мэдээллийг өгөөгүй тухай тайлбарыг хүсэлтдээ дурдсан байна. Дахин хянан үзэх хүсэлтийг 7 хоногийн дотор мэдүүлээгүй бол хүсэлтийг хүлээн авахаас татгалзана. Гэхдээ 7 хоногийн хугацааг хэтрүүлэн мэдүүлсэн нэмэлт баримтыг хянан үзэх эсэхээ Herbalife компани өөрийн бүрэн эрх, үзэмжийн хүрээнд дангаар шийдвэрлэнэ.

#### **10.10.5 Гишүүнчлэлийн эрхийг цуцлах**

Хэрэв Гишүүн Дүрмүүдийг зөрчсөн бол Herbalife компани өөрийн бүрэн эрх, үзэмжийн хүрээнд дангаар шийдвэр гарган, Гишүүнчлэлийн эрхийг цуцалж болно.\*

Эрх цуцалсан арга хэмжээ нь Herbalife компаниас тухайн Гишүүнд хандсан бичгэн мэдэгдэлд заасан өдөр хүчин төгөлдөр болно. Эрхийг цуцалсны дараа Гишүүн нь эрх цуцалсантай холбоотойгоор Herbalife компанийн эсрэг нэхэмжлэл гаргахгүй байна.

Эрх цуцлагдсан Гишүүн нь\*\*:

- Гишүүний хувьд бизнесээ эрхэлж болохгүй;
- өөрийгөө Herbalife-ын Гишүүн хэмээн тодорхойлж болохгүй;
- Herbalife-ын борлуулалтын нэр, лого, тэмдэг болон бусад оюуны өмчийг ашиглаж болохгүй;
- Herbalife-ын сургалтууд, уулзалтууд, олон нийтийн арга хэмжээнүүд эсвэл промоушенд Гишүүний гэр бүлийн хүн эсвэл зочны хувиар ч оролцож болохгүй.

*\*Цуцлах гэдэг нь Гишүүнчлэлийн эрхийг бүрэн цуцалж, Herbalife-ын бизнес эрхлэх Гишүүний эрхийг хүчингүй болгоно гэсэн үг. Гишүүн нь тухайн Гишүүнчлэлийн эрхээс цаашид орлого хүлээн авах эрх цуцлагдах мөн энд багтана.*

*\*\*Эдгээр хориглох заалтууд нь Дүрмийн зөрчилтэй холбоотойгоор Herbalife-ын бизнесээс татгалзсан эсвэл ямар нэгэн байдлаар бизнесээ орхисон Гишүүдэд мөн хамааралтай.*

#### **10.10.6 Эрх цуцалсан шийдвэрт давж заалдах**

Гишүүн нь гишүүнчлэлийн эрх цуцлагдсан тухай шийдвэр гаргасан өдрөөс хойш 15 хоногийн дотор давж заалдаж болно. Гишүүн давж заалдахдаа дахин хянан үзэх шаардлагатай гэж үзэж буй нэмэлт мэдээллийг өгч болох бөгөөд шалгалтын явцад яагаад уг мэдээллийг өгөөгүй тухай тайлбарыг хүсэлтдээ дурдсан байна.

Давж заалдах хүсэлтийг 15 хоногийн дотор мэдүүлээгүй бол хүсэлтийг хүлээн авахаас татгалзана. Гэхдээ 15 хоногийн хугацааг хэтрүүлэн мэдүүлсэн нотлох баримтыг хянан үзэх эсэхээ Herbalife компани өөрийн бүрэн эрх, үзэмжийн хүрээнд дангаар шийдвэрлэнэ.

Давж заалдах өргөдлийг Борлуулалтын хэлтэс, Мэдээлэл Харилцааны Алба, Хуулийн хэлтэс тус бүрээс томилогдсон төлөөлөгчдөөс бүрдсэн хороо (цаашид “Хяналтын хороо” гэх) хянан шийдвэрлэнэ. Хяналтын хорооны олонхын шийдвэрээр гишүүнчлэлийн эрхийг цуцалсан арга хэмжээг зөв гэж үзэх, Гишүүнчлэлийн эрхийг сэргээх буюу эсвэл гаргасан зөрчилд өөр шийтгэл санал болгож болно. Эрх цуцалсан тухай шийдвэрийг хянан үзэхдээ Хяналтын хороо гаргасан уг зөрчил материаллаг эсэхийг харгалзан үзнэ.

Энэ шийдвэр нь алдсан орлогын нөхөн төлбөр төлөх үүрэг үүсгэхгүй байна.

## 10.11 Хуулийн нэмэлт заалтууд

**“Гэрээ”-ний доорх тайлбарууд нь Гишүүн болон Herbalife-ын хоорондох хүсэлт болон гэрээний бүх харилцаанд хамааралтай.**

### 10.11.1 Хохирол

Холбогдох хуулиар зөвшөөрөгдсөн бүхий л хүрээнд, Herbalife компани болон Гишүүн аль аль нь бие биеийнхээ өмнө хохирол учирч болохыг аль нэг тал мэдэж байсан эсэхээс үл хамааран, холбогдох ямарваа хууль эсвэл адилтгах үндэслэлийн хүрээнд сайн нэр, бизнес боломжууд, хэлэлцээр, ашиг эсвэл орлого зэрэгт нөлөөлсөн ямарваа шууд бус, санамсаргүй, гарцаагүй, жишээ болгох байдлаар хийсэн, эсвэл байцаан шийтгэлийн хохирлуудын төлөө хариуцлага хүлээхгүй.

### 10.11.2 Эрхээсээ татгалзах буюу эсвэл хугацаа алдаж эрхээ эдлэх

Herbalife компани нь Дүрэм зөрчсөн болон Гишүүнтэй байгуулсан Гэрээг зөрчсөн асуудлыг дан ганц өөрийн бүрэн эрх, үзэмжийн хүрээнд шийдвэрлэж болно. Herbalife компани Гэрээний дагуу эдлэх эрхээ хэрэгжүүлээгүй, хэрэгжүүлэхээс татгалзсан, эсвэл уг эрхээ үл тоомсорлосон үйлдэл нь Herbalife компани тухайн заалтын дагуу эсвэл тухайн гэрээгээр дурын үед эдлэх эрхээсээ татгалзсан гэсэн үг биш.

### 10.11.3 Тусгаар байдал

Хэрвээ Гэрээний аль нэг заалт ямар нэг талаараа хүчингүй, хууль бус, хэрэгжүүлэх боломжгүй гэж тогтоогдвол тухайн заалтыг гэрээнээс хасах бөгөөд энэ нь гэрээний үлдсэн хэсэгт ямар ч нөлөө үзүүлэхгүй байна. Гэрээний бусад хэсэг хүчин төгөлдөр, үйлчлэлтэй хэвээр байна. Түүнчлэн, хасагдсан тухайн заалттай аль болох адил бөгөөд хууль ёсны, хүчин төгөлдөр, хэрэгжүүлэх боломжтой өөр заалтыг тухайн Гэрээнд автоматаар нэмж оруулна.

### 10.11.4 Хэрэглэх хууль, маргаан шийдвэрлэх газар

Herbalife компани Гишүүн хоёрын хоорондын харилцаанаас үүдсэн аливаа маргаан нь хууль эрхзүйн зөрчилдөөний зарчмуудыг хэрэглэхгүйгээр Монгол улсын хуульд захирагдана.

Маргааныг гагцхүү Монгол улс, Улаанбаатар хотод орших харьяа эрх бүхий шүүхэд шийдвэрлүүлнэ.

### 10.11.5 Хохирлыг нөхөн төлөх

Гишүүн нь Гэрээг зөрчсөнөөс эсвэл Гишүүний эрхэлж буй Herbalife -ын бизнестэй холбоотойгоор үүссэн аливаа зарга, үйлдэл, албан шаардлага, прокурорын ажиллагаа, эсвэл нэхэмжлэл болон эдгээртэй холбогдон гарах зардал, өр төлбөрөөс Herbalife компанийг хохиролгүй болгон нөхөн төлөх, хамгаалах буюу хохиролгүй байлгана. Herbalife компани нь хохирлын нөхөн төлбөртэй холбоотой үүссэн ямарваа үүргийг гүйцэлдүүлэхийн тулд мөнгөн дүнг тухайн Гишүүнд олгохоор байгаа мөнгөн дүнгээс суутгаж болно.

### 10.11.6 Гишүүд хоорондын нэхэмжлэл

Нэг Гишүүний аливаа үйлдэл, эс үйлдэл, баталгаа, мэдэгдлийн улмаас өөр нэг Гишүүнд шууд буюу шууд бусаар учирсан аливаа өртөг, зардал, алдагдал, хохиролд Herbalife компани хариуцлага хүлээхгүй байна.

## 10.12 Мэдээллийн аюулгүй байдал ба нууцлал

“Гербалайф Интернэшнл РС” ХХК | 105064, Москва хот, Земляной Вал гудамж, 9-р барилга, 12-р давхар, байр I, 1, 3-7-р өрөө (цаашид “Herbalife” гэх) нь таны талаарх хувийн мэдээллийг хянадаг компани. Herbalife компанийн заавраар Универсал Ложистикс Монголия, Монгол улс, Улаанбаатар хот, БГД, 24-р хороо, Тээвэрчдийн гудамж, “Four season village” хотхоны худалдаа үйлчилгээний төвийн 1 давхар (цаашид “Юниверсал” гэх) компани нь Гишүүдийн талаар хувийн, танин тогтоож болох тодорхой мэдээллийг (ХМ) цуглуулж, Herbalife компанид хангаж өгдөг. Хүсэлтийн маягт дээрх ХМ-ээс гадна Herbalife болон Универсал компани Гишүүнчлэлийн дагуу хүлээсэн Гишүүдийн үүргийн биелэлтийг хангахад шаардагддаг Гишүүдийн банкны данс, кредит картын дугаар гэх мэт Гишүүдийн бизнесийн болон бусад мэдээллийг цуглуулдаг. Хэрвээ Гишүүн нь Herbalife болон Универсал компанид эдгээр мэдээллийг хангаж өгөх буюу эсвэл мэдээллийг хэрэглэх зохистой зөвшөөрлийг өгөхөөс татгалзвал тухайн хүн Гишүүн хэвээр үлдэх боломжгүй\*. Хэрэв Гишүүн нь Herbalife болон Универсал компанид эдгээр мэдээллийг хангаж өгвөл, мэдээллийг дараах зүйлст ашиглана. Үүнд:

1. Гишүүдэд үйлчилгээ үзүүлэх (захиалга хүлээн авах болон захиалгыг хянан үзэх, орлогыг тооцоолж бодох гэх мэт);
2. Гишүүдийн үйлчлүүлэгчдэдээ үзүүлдэг үйлчилгээг дэмжих, сайжруулах;
3. Гишүүдийг нэмэлт үйлчилгээгээр хангах;
4. [Борлуулалт, маркетингийн төлөвлөгөөний](#) чиг үүргийг зохистой хэрэгжүүлэх, хадгалах;
5. Дүрэм журмын биелэлтийг хангах.

Herbalife компани нь Гишүүдийн мэдээллийг өөрийн харьяа охин компаниуд\*\*, Америкийн Нэгдсэн Улс дахь өөрийн толгой компани, үйлчилгээ ханган нийлүүлдэг гуравдагч талууд (жишээлбэл мэдээллийн технологийн (IT) дэмжлэг үзүүлдэг, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд болон хуулийн зөвлөхүүд гэх мэт), мөн шаардлагатай үед Гишүүдийн дээд үеийн багийн гишүүдэд өгдөг. Тодорхой тохиолдлуудад мөн Herbalife компани Гишүүдийн мэдээллийг хуулийн хүрээнд төрийн эрх бүхий байгууллагуудад хангаж өгөх үүрэгтэй болж болно. Эдгээр бүх тохиолдлуудад Herbalife компани Гишүүдийн мэдээллийн нууцлалыг хангах зохистой арга хэмжээг авах болно. Herbalife компани та бүхний мэдээллийг өөр аливаа гуравдагч талд өгдөггүй.

Herbalife компанийн зарим харьяа болон охин компаниуд болон Гишүүдийн дээд эгнээнийхэн тухайн Гишүүний амьдардаг улс орноос хувийн мэдээллийн нууцлалыг бага хангадаг өөр улс оронд байдаг байж болно. Гэхдээ Herbalife компани нь Гишүүдийн мэдээлэл ашиглагдаж буй аливаа улс оронд Гишүүдийн мэдээллийн нууцлалыг хангах, хамгаалахад тууштай хүчин чармайлт гаргадаг бөгөөд Herbalife International of America, Inc. компани нь Европын Холбоо-АНУ хооронд байгуулсан хувийн мэдээллийн нууцлалыг цогцоор хангах Safe Harbor гэрээнд батламжлагдан орсон бөгөөд танай улс оронд хэрэгжүүлдэг хувийн мэдээллийн нууцлалыг хангах хамгаалалттай эн тэнцүү түвшний хамгаалалтыг тууштай хангах үүрэг хүлээсэн.

Гишүүд өөрийн хувийн мэдээлэлд нэвтрэх болон алдаатай мэдээллийг засуулах эрхтэй. Хэрэв Гишүүд энэ эрхээ эдлэхийг хүсвэл өөрийн орон нутаг дахь Мэдээлэл Харилцааны Албатай холбогдох хэрэгтэй. Өөрийн аккаунтын мэдээллийг [www.myherbalife.com/mn-MN](http://www.myherbalife.com/mn-MN) хаягаар орж шалгах буюу эсвэл [privacy@Herbalife.com](mailto:privacy@Herbalife.com) хаягаар цахим захидал илгээж болно.

Аливаа цаг үед Herbalife компани Гишүүдэд тухайн Гишүүдийн доод үеийн багийн гишүүдтэй холбоотой ХМ-ийг өгч болно. Гишүүд нь доод үеийн багийн гишүүдээсээ тэдний мэдээллийг өөр зорилгод ашиглаж болно гэсэн зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд зөвхөн өөрийн доод үетэй Herbalife-ын бизнесийн харилцаа тогтоох зорилгоор энэхүү ХМ-ийг ашиглаж болно. Гишүүд олон улсын түвшинд мэдээ баримт шилжүүлэхэд тавигддаг хориг хязгаарлалтууд болон мэдээ баримтыг хамгаалахтай холбоотой холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх ёстой. Herbalife компаниас Гишүүнд ХМ өгсөн бол тухайн Гишүүн уг ХМ-ийг хариуцаж, нууцлалыг чандлан хадгалах үүрэг хүлээнэ. Бизнесээ хөгжүүлэхэд нь Гишүүдэд туслах үүднээс Herbalife компани өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тухай материалыг Гишүүдэд өгнө.

Мөн Herbalife компани нь Herbalife компанийн тухай болон түүний бизнесийн түншүүд, хамтрагч нарын тухай бизнесийн мэдээллийг Гишүүдэд илгээж болно. Бизнесийн хөгжил, сурталчилгааны хэрэгслүүдийг хүлээн авахаас татгалзахыг хүсвэл та Хүсэлтийн маягт дээрээ холбогдох дөрвөлжин нүдэнд тэмдэглэгээ хийх буюу эсвэл 18001101 дугаарын утсаар Мэдээлэл Харилцааны Албатай холбоо бариарай.

\* Гишүүн Гишүүнчлэлийн эрхээ цуцлуулсан тохиолдолд Herbalife компани тухайн Гишүүний зарим мэдээллийг НББ-ийн зорилгод болон Борлуулалтын, Маркетингийн Төлөвлөгөөний дагуу орлогын тооцоолол хийх зорилгоор хадгалж үлдэх ёстой.

\*\* Herbalife компанийн харьяа буюу охин компаниудын жагсаалтыг [www.myherbalife.com/mn-MN](http://www.myherbalife.com/mn-MN), эсвэл [www.herbalife.mn](http://www.herbalife.mn) хаягаар орж үзэж болно.

## 10.13 Нэр томъёоны тодорхойлолт

**Өргөдөл ба гэрээ:** Herbalife-ын гишүүнчлэлийн өргөдөл, гэрээ, Гишүүн болон Herbalife хоорондын гэрээний дагуух бүх харилцаа, үүнд Борлуулалт ба маркетингийн төлөвлөгөө, Мөрдлөг болгох дүрэм болон [MyHerbalife.com](http://MyHerbalife.com) дээр байрлуулсан бусад баримт бичиг хамаарна.

**Нэгтгэх:** Гэрлэлт цуцлуулсан болон хамтран амьдрагчийн харилцааг цуцлуулсан тохиолдолд анхдагч Гишүүнчлэлийн эрхийн оноон дээр гэрлэлтээ цуцлуулсан буюу хамтран амьдрагчийн харилцаагаа цуцлуулсан хүмүүсийн тусдаа салангид болсон Гишүүнчлэлийн эрхийн оноог орлогын хувь тооцоолох зорилгоор нэгтгэх ажиллагаа.

**Бизнесийн арга хэрэгсэл:** Herbalife компаниас хангаж өгөөгүй борлуулалтын туслах хэрэгсэл.

**Мэдэгдэл:** Herbalife®-ын бүтээгдэхүүн эсвэл Herbalife-ын бизнесийн боломжийн талаарх аливаа мэдэгдэл, түүх, зураг эсвэл видео.

**Клуб:** Эрүүл Амьдралын Хэв Маягийн Клуб.

**Арилжааны клуб:** Орон сууцны бус байршилд байрлах клуб.

**Компани:** Herbalife Дистрибьюшн ХХК

**Үйлчлүүлэгч:** Давуу эрхтэй үйлчлүүлэгчид болон жижиглэнгийн хэрэглэгчид

**Хураамж:** Гишүүнчлэлийн үйлчилгээний жил бүрийн хураамж.

**Ерөнхий олон нийт:** Гишүүн өмнө нь ямар нэгэн байдлаар харилцаа холбоо тогтоогоогүй хүмүүс.

**Herbalife компанийн оюуны өмч:** Herbalife компанийн зохиогчийн эрхтэй материалууд, худалдааны тэмдгүүд, худалдааны нэр, брэнджүүлэлт, худалдааны нууц орно.

**НМР буюу Гэрээний багц:** Herbalife-ын гишүүний багц. Гэрээний багц бол Herbalife-ын гишүүдэд зориулсан бизнес эхлүүлэх хэрэгсэл юм.

**Herbalife®-ын бүтээгдэхүүн:** Herbalife-аас худалдаалж буй бүх бүтээгдэхүүн мөн тэдгээр бүтээгдэхүүнийг ашиглан гишүүдийн хийсэн зүйлс багтана.

**Herbalife-ын сэтгэл ханамжийн баталгаа:** Бүх үйлчлүүлэгчдэд зориулсан Herbalife-ын төлбөр буцааж өгөх 30 хоногийн хугацаатай баталгаа.

**Leads буюу боломжит үйлчлүүлэгч:** Herbalife®-ын бүтээгдэхүүний эсвэл Herbalife-ын бизнесийн боломжийг сонирхож буй хүмүүс.

**Хамтран амьдрагч:** “Хамтран амьдрагчийн нэрийг нэмж оруулах хүсэлт”-д Herbalife-ын Гишүүн өөрийн хамтран амьдрагч гэж заасан хүн.

**Амьдралын хэв маягийн тухай мэдэгдэл:** Орлогын тухай мэдэгдлийн нэг хэлбэр. Гишүүн Herbalife-ын бизнест нэгдсэнээр тодорхой амьдралын хэв маягийг олж авах эсвэл тодорхой эд зүйлсийг худалдан авах боломжтой гэсэн аливаа илэрхий эсвэл далд мэдэгдэл.

**Доод багийн тайлан:** Эдгээр тайлангууд нь гишүүний доод багийн бусад гишүүд болон давуу эрхт үйлчлүүлэгчдийн талаарх тэдний нэр, холбоо барих мэдээлэл, Herbalife-ын ID дугаар, түвшин, статус, оноо, борлуулалтын статистик зэрэг бизнесийн үзүүлэлт зэрэг мэдээллийг агуулдаг.

**Материал:** Herbalife компанийн боловсруулан гаргасан материал, борлуулалтын туслах хэрэгсэл.

**Гишүүн:** Herbalife гишүүнчлэлийн өргөдөл, гэрээг хүлээн авч, Herbalife-ын бүртгэлд оруулсан хувь хүн.

**Гишүүнчлэл:** Herbalife-ын гишүүний бие даасан бизнес.

**Мэдээлэл харилцааны алба:** +976 1800-1101 дугаарын утсаар холбогдож болох Herbalife компанийн мэдээлэл харилцааны алба.

**Эрүүл амьдралын хэв маягийн клуб:** Эрүүл амьдралын хэв маягийн клубүүд нь Herbalife®-ын бүтээгдэхүүнийг хэрэглэснээр зөв хооллолтод анхаарахыг хүсдэг хүмүүст зориулсан дэмжлэг үзүүлдэг газар юм.

**Эрүүл амьдралын хэв маягийн клубийн зохион байгуулагч:** "Зохион байгуулагч" гэж Herbalife-ын гишүүн бөгөөд Эрүүл амьдралын хэв маягийн клуб ажиллуулдаг хүнийг хэлнэ.

**Хувийн мэдээлэл:** Нэр, овог, шуудангийн хаяг, хот, муж, зип код, утасны дугаар, имэйл хаяг, зээлийн карт, банкны мэдээлэл зэрэг хувь хүний мэдээлэл.

**Давуу эрхт үйлчлүүлэгч:** Давуу эрхт үйлчлүүлэгч нь Herbalife®-ын бүтээгдэхүүнийг шууд Herbalife-аас хөнгөлөлттэй үнээр худалдан авах эрхтэй. Давуу эрхт үйлчлүүлэгч нь (1) Herbalife®-ын бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулах; (2) Herbalife-ын Гишүүн эсвэл давуу эрх үйлчлүүлэгч байхын тулд бусдыг бизнест татан оруулах эсвэл спонсорлох; эсвэл (3) Борлуулалт ба маркетингийн төлөвлөгөөний дагуу урамшуулал авах эрхгүй юм.

**Хяналтын хороо:** Гишүүнчлэлийн эрх цуцалсан шийдвэрт давж заалдсан гомдлыг хянан шийдвэрлэх хороо. Борлуулалтын хэлтэс, Мэдээлэл Харилцааны Алба, Хуулийн хэлтэс тус бүрээс томилогдсон нэг нэг төлөөлөгчдөөс бүрдсэн байна.

**Мөрдлөг болгох дүрэм:** Herbalife-аас үе үе гаргадаг Herbalife-ын гишүүний дүрэм, бодлого, зөвлөмжүүд.

**Борлуулалт ба маркетингийн төлөвлөгөө:** Herbalife компанийн [борлуулалт ба маркетингийн төлөвлөгөө](#).

**Спонсор:** Өөр хувь хүнийг Herbalife-ын Гишүүн болгон оруулж буй Гишүүн.

**Гуравдагч этгээдийн сайтууд:** Дуудлага худалдааны сайтууд болон гуравдагч этгээдийн маркетинг буюу цахим худалдааны талбар.

**Эрх шилжүүлэн авсан хүн:** Гишүүнчлэлийн эрхийг шилжүүлэн авч буй Гишүүн.

**Эрх шилжүүлж буй хүн:** Гишүүнчлэлийн эрхээ өөр хүнд шилжүүлж буй хуучин Гишүүн.